



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-8</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>9-36</i>

<i>I.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	<i>9-36</i>
--	-------------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 10 дугаар
сарын 23-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, П.Сайнзориг, Л.Энхнасан;
Чөлөөтэй: Н.Номтойбаяр, Дам.Цогтбаатар.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлогын газрын дарга З.Баярхүү, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Ю.Энхтуяа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын

менежер Ю.Энхтуяа, аудитор Ж.Мөнхбилгүүн, аудитор Г.Оюунтөгөлдөр, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Намсрай, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Я.Гантөмөр, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Тамгын газрын дарга Б.Баасанцогт нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Алтан нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Д.Ганбат, Ч.Анар, Э.Болормаа, Б.Жаргалан, Х.Жангабыл, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Намсрай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлогын газрын дарга З.Баярхүү нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын IX.1.1-д тусгасан “Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/ арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 19
Бүгд: 20
5.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа саналаа тайлбарлав.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 19.1.1.2-т тусгасан “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт” гэснийг “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж” гэж, “хувь” гэснийг “тоо” гэж, мөн 19.1.1.3-т тусгасан Хэмжих нэгжийн “хувь” гэснийг “тоо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 12
Бүгд: 20
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 19.1.1.2-т тусгасан “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт” гэснийг “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж” гэж, “хувь” гэснийг “тоо” гэж, мөн 19.1.1.3-т тусгасан Хэмжих нэгжийн “хувь” гэснийг “тоо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын **70301 Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа** хөтөлбөрт дараах агуулгатай арга хэмжээ нэмэх:

“23.2.2 “Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулах”
Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.2.2.1
Шалгуур үзүүлэлт: Гадаад улстай хийх хэлэлцээр
Хэмжих нэгж: Тоо
Суурь он: 2023
Суурь түвшин: 64
2025 оны зорилтот түвшин: 75” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9

Бүгд: 20
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын **70301 Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа** хөтөлбөрт дараах агуулгатай арга хэмжээ нэмэх:

“23.2.2 “Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулах”
Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.2.2.1
Шалгуур үзүүлэлт: Гадаад улстай хийх хэлэлцээр
Хэмжих нэгж: Тоо
Суурь он: 2023
Суурь түвшин: 64
2025 оны зорилтот түвшин: 75” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5 гэсэн хөтөлбөр нэмэх:

“23.5 Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 11
Бүгд: 20
45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар саналаа тайлбарлав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5 гэсэн хөтөлбөр нэмэх:

“23.5 Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5.1 гэсэн арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөр 23.5.1
Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн
“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.5.1.1
Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт
Хэмжих нэгж: Хувь
Суурь он: 2023
Суурь түвшин: 95
2025 оны зорилтот түвшин: 100” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөр 23.5.2
Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн
“Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
Шалгуур үзүүлэлтийн дугаар: 23.5.2.1
Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт
Хэмжих нэгж: Хувь
Суурь он: 2023
Суурь түвшин: 95
2025 оны зорилтот түвшин: 100” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын **70601 Зэвсэгт хүчний үйл ажиллагаа** хөтөлбөрийн 27.1.1 дэх арга хэмжээг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулах:

“27.1.1 Зэвсэгт хүчнийг “Нисгэгчгүй нисэх хэрэгсэл” “Дрон”, “Хиймэл оюун ухаан”-д суурилсан дэвшилтэт техник, хэрэгслээр хангах

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.1.1

Шалгуур үзүүлэлт: Техник хэрэгслийн хангалт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 8.5

Зорилтот түвшин: 20” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын **70601 Зэвсэгт хүчний үйл ажиллагаа** хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.2 Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.2.1

Шалгуур үзүүлэлт: Бэлэн байдлын түвшин

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 18

Зорилтот түвшин: 28” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын **70601 Зэвсэгт хүчний үйл ажиллагаа** хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.3 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.3 Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.3.1

Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 25

Зорилтот түвшин: 30” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 8

Бүгд: 20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын **70601 Зэвсэгт хүчний үйл ажиллагаа** хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.4 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.4 Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.4.1

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт

Хэмжих нэгж: Хувь

Суурь он: 2023

Суурь түвшин: 10

Зорилтот түвшин: 15” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжисин
Д.Сүхбаатар” танхим 12 цаг 30 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Чинбаатарын Анар гишүүн,
Батын Батбаатар гишүүн,
Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн,
Энхбатын Болормаа гишүүн,
Дашидондогийн Ганбат гишүүн,
Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн,
Хажикбэрийн Жангабыл гишүүн,
Нанзадын Наранбаатар гишүүн,
Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн
Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн,
Жадамбын Энхбаяр гишүүн.
Арвижихын Эрдэнэбүрэн гишүүд
хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын
хорооны ирц бүрдсэн байна аа.

Ингээд ирц бүрдсэн тул 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд бас танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, 2 дахь хэлэлцүүлэг байгаад байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Ингээд 2025 оны төсвийн тухай хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг оруулаарай.

Та бүхэнд хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг бас танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна аа. Жавхлан сайдыг микрофонд урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хороон дарга, эрхэм гишүүддээ өглөөний мэндийг эрье ээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна аа.

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд Алсын хараа-2050 шинэ сэргэлтийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформ эдийн засгийн суурийг тэлж хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Ирэх 2025 он нь Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх орон нутаг бие даан хөгжихөд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс онцлогтой юм аа.

Төрийн цэргийн байгууллагын албан хаагчдын бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, офицер, ахлагч, хугацаат болон гэрээт албан хаагчид, сонсогчийн дүрэмт хувцас, хэрэглэлээр хангах, батлагдсан норм, стандартын дагуу шатах, тослох материал, хээрийн дадлага, суурилуулалт, машин, техник хэрэгслийн урсгал засвар, үйлчилгээ эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, цэргийн алба хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүний эрхэд суурилсан хүний хүн төвтэй хандлагыг төлөвшүүлэх бодлогын хүрээнд холбогдох төсвийг тооцон тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн бодлого арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33.8 их наяд төгрөг, суурь зардал 32 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1.9 их наяд төгрөгийн эерэг байхаар байна.

Иймд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Ингээд Төсвийн тухай хуулийн төсөөлөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн

Загджав дарга танилцуулна. 5 номерын микрофоныг өгье. Зургаа юм байна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн өсөлтийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх урьдчилсан хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна аа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлага 35.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909.5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржсэн тэнцэл нь 1 их наяд 930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу

ДНБ-ий 2 хувьтай тэнцээж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ.

Үүнд:

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын урсгал зардлын төсвийг 3.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 22.3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1.6 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Гадаад харилцааны сайдын урсгал зардлын төсвийг 52 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 245.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 8.6 тэрбум төгрөг, байр ашиглалтай холбоотой урсгал зардлын 6.1 тэрбум төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 3.4 тэрбум төгрөг, томилолт, зочны зардлыг 6.9 тэрбум төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамжийн зардлыг 15.5 тэрбум төгрөг Засгийн газрын урсгал шилжүүлгийг 8.9 тэрбум төгрөг тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 4 төсөл арга хэмжээнд нийт 30.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж төлөвлөсөн байна аа. Батлан хамгаалахын сайдын урсгал зардлын төсвийг 191.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 749.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 96.6 тэрбум төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10.2 тэрбум, хангамж бараа материалын зардлыг 6.7 тэрбум, норматив зардлыг 17.6 тэрбум, эд хогшил, урсгал засварын зардлыг 19.8

тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 22 тэрбум, төрийн өмчит байгууллагад олгох татаасыг 5.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсвийн нийт 4 төсөл арга хэмжээнд нийт 84.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна аа.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан байна гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Загджав даргад баярлалаа.

Та бүхэнд хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Жамъяншиаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандаг Ичинноров, Сангийн яамны Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн

яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Сангийн яамны Санхүүгийн Зээл даатгалын хэлтсийн дарга Батбаатарын Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга Зандангийн Баярхүү, Үндэсний аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав, Монгол Улсын ерөнхий аудитын орлогч Ядамын Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Санхүү-нийцлийн Аудитын газрын дарга аудитын менежер Лувсандагвын Мөнхцацрал, Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын аудитын менежер Юрагийн Энхтуяа, Санхүү-нийцлийн Аудитын газрын аудитор Жанчивдоржийн Мөнхбилгүүн, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Ган-Үнэрийн Оюунтөгөлдөр гэсэн ийм бүрэлдэхүүн байна.

Батлан хамгаалахын яамнаас Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт сайд байна. БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг, мөн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Найдангийн Цэвэлмаа гэж орж байна. ГХЯ-аас Батцэцэг сайд байна уу? Батцэцэг сайдыг дуудаарай. ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Лханаажавын Мөнхтүшиг, Мөнхтүшиг дарга алга байна дуудаарай. ГХЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Чүлтэмийн Ганбат. ЗХЖШ-аас Жанжсин штабын дарга хошууч генерал Ганбямба дарга байна. ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн дарга хурандаа Балжиннямын Бүрэнтөгс, ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал Думаагийн Намсрай, Санхүү ард талын газрын дарга Ядмаагийн Гантөмөр, мөн Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга хошууч Төрмандахын Мөнх-Эрдэнэ гэсэн бүрэлдэхүүн байна.

Цөмийн энергийн комиссоос Комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Гунаажавын Манлайжав, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Балдоржийн Баасанцогт гэсэн бүрэлдэхүүнтэй байна аа.

Хууль санаачлагчаас болоод Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Анар гишүүнээр тасаллаа. Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе ээ.

Тэгэхээр БХЯ-ны төсвийг харж байсан. Тэгээд 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл хамгийн их нь зам тээврийн салбарт 35 хувь нь, эрчим хүчний салбарт 6.7 хувь нь, инженер дэд бүтцийн салбарт 9.1 хувь, боловсролын салбарт 11.9 хувь нь энэ хуваарилагдаж байгаа.

Асуулт нь болохоор зэрэг батлан хамгаалах салбарт энэ хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь хуваарилагдаж байна. ДНБ, Үндэсний нийт бүтээгдэхүүний хэдэн хувийг бас батлан хамгаалах салбартаа манай улс хуваарилдаг юм. Бусад улс орон батлан хамгаалах салбартаа хэдэн хувийг нь хуваарилдаг юм бэ гэсэн нэг ийм харьцуулсан судалгаа байна уу гэдэг дээр асуулт асуумаар байгаа юм. Тэгээд яагаад асууж байгаа юм гэхээр зэрэг батлан хамгаалах салбарын маань хөрөнгө оруулалтууд жилийн жилд төсөв дээр их муу тавигддаг. Бодит байдал дээр очоод харахад анги салбаруудын байгаа байдал урсгал засвар шинэ барилга байгууламж бол сүүлийн жилүүдэд нэмэгдээгүй. Хуучин байгаа барилга байшингууд нэлээн муудчихсан. Урсгал засвар нэн хийх шаардлагатай, нэн түргэн хугацаанд хийх шаардлагатай ийм нөхцөл байдлууд байсаар байгаа.

Тэгэхээр өнөөдөр бодит байдал дээр харж байхад яг энэ цаг үед цэргийн татлага явж байгаа. Тэгээд өнөөдөр ерөөсөө цэрэгт явах сонирхолтой тийм залуучууд байхгүй болсон байна. Тэгээд яаж ийж байгаад л нэг мултарч үлдэх эрүүл мэндийн шалтгаанаар байдаг юм уу ямар нэгэн байдлаар цэрэгт явахгүй үлдэх гэсэн нэг ийм л залуучууд маань үзэл бодолтой болсон. Тэгээд энэнд нөлөөлж байгаа нэг томоохон хүчин зүйл бол энэ цэргийн анги салбаруудын очоод байрлах тэр орчин нөхцөл хүүхдүүдээ тэр эцэг эхчүүдийн очоод байлгах орчин нөхцөл тааруу.

Дээрээс нь энэ цэргийнд очиж байгаа залуучуудын сургалтын хөтөлбөр сайн биш. Зөвхөн цэргийн хэргийн мэдлэг орохоос хажуугаар нь мэргэжлийн ур чадвар, англи хэл, жолооны курсийн хичээл гэх мэтчилэн энэ сургалтын хөтөлбөрүүд тааруу. Тэгээд энд тавьдаг төсөв хөрөнгө муу. Тэгээд энэ байдлуудаас болоод өнөөдөр ер нь цэрэгт явах энэ бодол энэ хүсэл зориг байхгүй болсон юм болов уу гэж ингэж хардаг.

Тийм учраас энэ төсөв дээр эд нарыг өөрчлөхөд зориулж ямар ажлууд хийхээр, ямар төсвүүд ирэх 2025 онд тавьчихваа гэсэн ийм асуулт байна.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Ер нь батлан хамгаалах салбарын төсөв бол ер нь бусад салбаруудаас харьцангуй бага тавигддаг ийм уламжлалтай юм байна лээ. Өнөөдөр дэлхийн бас энэ геополитик, гео улс төр, гео стратегийн байдал нэлээн бас амаргүй хүнд байгаа. Бүх л дэлхийн бүх улс орнууд батлан хамгаалах салбартаа зарцуулах төсвөө бүгд нэмэгдүүлж байгаа. Бид нар судалгаа хийгээд үзсэн яг манайхтай ижил цөөн хүн амтай бас томоохон энэ гүрнүүдтэй хиллэдэг ийм улсууд тухайлах юм бол Гүрж, Латви, Литва тэгээд цаашилаад Израил гээд

улсуудыг бас харьцуулаад ингээд судалгаа хийгээд үзэхэд хамгийн багадаа нийт ДНБ-ийхээ 2 хувийг батлан хамгаалах салбартаа зарцуулдаг. Дээд тал нь 10 хувь, 15 хувь хүртэл зарцуулдаг юм байна лээ. Манай улсын хувьд аваад үзэх юм бол ДНБ-ий 0.6-аас 0.7 хувийг батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд зарцуулж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол бусад улс орнуудтай харьцуулах юм бол хамгийн өндөр улстай харьцуулах юм бол 20 дахин бага, хамгийн бага төсөв зарцуулж байгаа улстай харьцуулах юм бол 3-аас 4 дахин бага төсвийг батлан хамгаалах салбарт зарцуулж байгаа. Ер нь улс төрийн нөхцөл байдал бас гео улс төрийн нөхцөл байдал бас тийм амаргүй байж байгаа. 2 хөрштэй 2 хөрш маань хоёулаа. бас л нэлээн асуудалтай. Энэ үед бас хэрвээ ингээд бид бас цаашидаа бас нэлээн тийм бодох, болгоомжлох, энэ батлан хамгаалах салбартаа бас илүү анхаарах онцгой анхаарах ийм шаардлагатай цаг үед л ажиллаж амьдарч байгаа. Үүнийг бас манай Улсын Их Хурлын гишүүд олон нийт бас илүү ойлгоосой гэж хүсэж байгаа.

Дотоодын салбартаа аваад үзэхэд ч гэсэн бас ялгаа байхгүй 2024 онд ХЗДХ-ийн сайдын багцад хөрөнгө оруулалт 400 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавигдсан. Батлан хамгаалах сайдын багцад 20 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавигдсан байгаа юм. Бас 20 дахин бага, 2024 онд. Харин бас 25 онд бол бас манай Сангийн яам, Засгийн газар дээр бид нар бас тодорхой бас нөхцөл байдлаа ойлгуулж байж тодорхой хэмжээгээр хөрөнгө оруулалтын хувь татвар нэмэгдэж. Бага зэрэг нэмэгдэж байгаа. Энэ дээр бас Сангийн яамныханд бас талархлаа бас хэлэх гэсэн нь зөв байх аа.

Цаашидаа бидний өмнө бас тулгамдсан олон асуудлууд байна. Сая та бас хөндөж ярьж байна. Бид нар энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцдог

энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа. Эндээс тодорхой орлого олдог. Цэргийн албан хаагч нар маань ч орон байрныхаа урьдчилгааг нэг 50 орчим сая төгрөгийн бас асуудлаа шийдээд ирдэг. Зэвсэгт хүчний хөгжлийн санд ч тодорхой мөнгө ордог. Гэтэл үүнд ашиглаж байгаа нөгөө зэвсэг техник нь хуучирчихсан НҮБ-аас бас оролцуулахгүй байх ийм шаардлага тавьж байгаа. Тийм болохоор зэвсэг техникээ сайжруулж энэ НҮБ-аас олдог орлогоо нэмэгдүүлэх ийм шаардлага бидэнд байна.

Хоёрдугаарт нь таны сая бас хэлж байгаа хугацаат цэргийн албан хаагчтай холбоотой хугацаат цэргийн албан хаагч нар нь алба хаах сонирхол маш их буурч байгаа. Үүнийг бас нэмэгдүүлье. Бас хугацаат цэргийн албан хаагч, цэргийн эрдэмд суралцахаас гадна бас ажил амьдрал дээр гараад бас амьжиргааны орлого олчих чадалтай чадвартай болоосой гэдгийн үүднээс англи хэлний анхан шатны мэдлэгтэй болгох, компьютерын анхан шатны мэдлэгтэй болгох мөн бас жолооны курст суралцах гэх мэтийн бас ийм бололцоонууд бүрдүүлэх талаар бид нар анхаарч тодорхой ажил төлөвлөж байгаа. Энэ төлөвлөж байгаа ажлуудыг бас хийж хэрэгжүүлэхэд мэдээж компьютероос авхуулаад сургалтын машин механизмаас авхуулаад анги танхимын ширээ сандлаас авхуулаад бас бидэнд шаардлагатай тоног төхөөрөмж хөрөнгө оруулалтыг шийдэх шаардлага байгаа юм.

Ийм байдлаар бид нар бас энэ хугацаат цэргийн албан хаагчдаа бас нэг чадавхжуулаад авчихвал өнөөдөр бас Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр бас ажил хийчих чадвартай, чадалтай цэргийн эрдэмд суралцсан ийм бас боловсон хүчнүүд бий боллоо гэж үзэж байгаа. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд бас анхааралдаа авч бас цаашидаа манай энэ төсвийг боломжийн хэмжээнд.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр цаашидаа бол бид нэг ийм байдалтай явахад хэцүү байх юм байна аа. Тийм учраас цэрэг татлагын дүнгээс харж байхад аймгуудад өгсөн цэргийн штабуудад өгсөн хяналтын тоо бол хаанаа ч хүрэхгүй байгаа. Нийт татагдахаар авчирсан үзлэгт оруулж байгаа залуучуудын 50-аас илүү он тэнцэхгүй. Тэгээд ямар нэгэн шалтгаанаар ийм байгаа. Тийм учраас цаашидаа цэрэгт хугацаат цэргийн алба хаах гэж байгаа залуучуудын энэ зээлийг тэр цэргийн алба хаах хугацаанд нь царцаах ч байдаг юм уу, татварын тодорхой хөнгөлөлт үзүүлэх, эргээд их дээд сургуульд сурахад нь тэтгэмж олгодог байх ажил төрөлд ороход нь бас давуу байдал харгалзаж үздэг байх гэх мэтчилэн олон өөрчлөлтүүдийг цаашидаа хийхгүй бол манай батлан хамгаалах салбар маань бас чадамж муутай болох ийм байдал бас ажиглагдаж байна.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо. Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Яах вэ ерөнхийдөө бол гадна дотнын нөхцөл байдал тийм амаргүй байгаа л даа. Тэгээд энэ нөхцөл байдалтай уялдуулаад бас бид нарын бодлого шийдвэр арай өөр байх ёстой гэж ойлгож байна. Батлан хамгаалах салбар маань бас их хүнд байдалд байна аа. Ийм байлгаж болохгүй л дээ. Ер нь одоо энэ 126 гишүүний хэд нь хугацаат цэргийн алба хаасан байдаг юм? Ер нь надаас өөр хүн алба хаасан юм уу ер нь айн? Энэ олон дарга нарын хэд нь алба хаасан байдаг юм? Уг нь тэр Үндсэн хуульд байгаа шүү дээ. Бүх нийтээрээ хүндэт үүрэг гэж цэргийн алба хаахыг тэр үүргээ биелүүлдэггүй. Одоо тэр цэргийн албанд тэнцдэг ийм залуучууд байхаа больж байна гэж хэлж байна. Бид нар жоохон бодлогоо өөрчлөөд бүх нийтийг цэргийн албанд хамруулсан нь дээр. Хугацаа бол нэг жил байна уу ямар байна тэрийг

багасгах хэрэгтэй? 6 сар болгох хэрэгтэй. Тэр зуны нөхцөлд орон байр шаардахгүй тэгж алба хаалгаж болдог. Тэр цэргийн эрдмийг нь бүрэн сургаад буцаах хэрэгтэй. Энэ талаар одоо зардал чирэгдэл тооцоо хийсэн юм байна уу? Өнөөдөр ерөөсөө 1 хувь ч хүрэхгүй байгаа л даа ДНБ-ий сая хэлж байх шиг байна. Тэр 0 хэдхэн хувь гээд. Тэгээд манай БХЯ маань юу байгаа юм, цэргийн анги ер нь дрон байна уу? Та нарт ганц ч дрон байхгүй байх аягүй л бол байгаа гэсэн үү, байгаа юм уу? Хэд байгаа юм? Ер нь хангалттай байгаа юу? Бусад улс орнууд дроны анги энэ тэр байгуулаад л шал өөрчлөгдөж эхэлж байна шүү дээ. Бид нар тоглоом биш л дээ. Энэ бол манай 2 хөрш бол том гүрнүүд. Энийг даваад бид нар аюул занал байхгүй гэж бодож байгаа боловч энэ эргэн тойрон ингээд бараг тосгон болгон цэрэгтэй болж эхэлж байна шүү дээ. Тэр компани болгон өөрийн гэсэн цэрэгтэй болж эхэлж байна. Тэгээд энэ хилийг чинь даваад ямар ч хүмүүс орж ирэх ийм магадлал байна шүү дээ.

Зуугаад жилийн өмнө ямар байлаа түүх давтагддаг гэгчээр. Тэгэхээр энд одоо бэлэн байна уу гэсэн ийм хэдэн асуултууд байна аа? Ер нь хэдэн хувь нь цэргийн алба хаагаад, хэдэн хувийг нь хаадаггүй юм? Хууль эрх зүйн орчин байсаар байтал яагаад тэгдэг юм. Энэ талаар ямар ажил хийж байна гэсэн ийм хэдэн асуултууд байна. Тэгээд гитлендээ багтахгүй цэргийн албан хаагч нар их олон байна шүү дээ. Энэ генерал дарга нар. Тэр Израилын цэргийг хар л даа. Ямар байна? Офицеруудыг нь. Эрэгтэй эмэгтэйгүй алба хааж байгаа. Манайх шиг цөөхөн хүнтэй Сингапур ч гэсэн бүгд алба хаадаг шүү дээ.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Монгол Улсын Үндсэн хуульд бас иргэн болгон цэргийн алба хаах ийм бас үүрэгтэй. Иргэн болгоноо бас цэргийн алба хаалгах бас бололцоо боломжийн хувьд бас манай

батлан хамгаалах салбарт бас тийм бололцоо бас боломж алга байна. Яг үнэндээ хугацаатай цэргийн алба хаах насны 18-аас 26 насны эрчүүдийг бүгдийг нь цэргийн алба хаалгана гэх юм бас төсөвт нэлээд их зардал гарна. Цэргийн албан хаагчдыг байрлуулах тийм үү? Сургах, цэргийн албанд сургах, байр сав хөрөнгө оруулалтаас авхуулаад тийм машин механизм, тоног төхөөрөмжөөс авхуулаад маш их хөрөнгө шаардлагатай болно. Яг өнөөдөр одоо ингээд нийт анги салбарт ашиглагдаж байгаа барилга байшингийн үндсэндээ 80 орчим хувь нь 50-аас дээш жилийн насжилттай болчихсон хуучирч муудсан. Бас нэлээд ихэнх байшингуудынх нь их засвар хийх шаардлагатай болчихсон байж байдаг. Одоо ашиглаж байгаа нөгөө машин механизм тоног төхөөрөмжүүдийн бас л тодорхой хувь нь элэгдэл хорогдолд орчихсон нэг иймэрхүү байдалтай байгаа. Эдгээр ингээд бүрэн шинэчлээд ингээд цэргийн албан хаагчийг цэргийн алба хаах нөхцөл бололцоог бүрэн хангая гэхэд төсөв мөнгө ч шаардлагатай. Гэтэл одоо нийт шаардлагатай төсөв мөнгөнийхөө дөнгөж 5 хувийг л бид нар санхүүжүүлж чадаж байна. Цаад 95 хувийг нь санхүүжүүлж чадахгүй байгаад байгаа юм. Тийм болохоор бас энийг 1 дүгээрт нь бодолцох асуудал байгаа.

Тийм болохоор хугацаат цэргийн албанаас гадна бид бас цэргийн алба хаах бусад төрлийн хэлбэрүүдийг ашиглаж байгаа. Дүйцүүлэх алба. Цэргийн албыг дүйцүүлж хааж байгаа, дүйцүүлж ж хаахдаа бол 10 гаран сая төгрөгийн төлбөр төлөөд шаардлагатай дуудсан үед дайчилгаанд бас оролцоод ингээд явдаг. Энэ төлбөрийг бас цаашид нэмэгдүүлэх хэрэгтэй юм байна аа. Энүүгээр бид нар бас дүйцүүлэх албыг бас нэмэгдүүлж энэ батлан хамгаалах салбарт шаардлагатай зардлаа олж авах мөн бас оролцуулж, цэргийн алба хаах бололцоо боломжийг бүрдүүлэх ийм байдлаар хаах.

Нөгөө оюутан цэрэг байгаа. Оюутан цэрэг бол харьцангуй сайн хэрэгжиж байгаа хөтөлбөр. Нийтдээ мянга орчим оюутан цэрэг хамруулж байна. 10 мянга орчим хүсэлт ирж байгаа. Тэгэхээр бол үндсэндээ оюутан цэргээ бас цааш нь үргэлжлүүлэх бас бололцоо боломж бас гарна гэж найдаж байгаа. Тоног төхөөрөмж материаллаг баазын тухайд бас шаардлагатай бол тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж чадахгүй байгаа. Тодорхой хэмжээгээр бид нар бас зарим анги нэгтгэлүүдээ бас таны хэлж байгаа орчин үеийн зэвсэг техникээр бүрдүүлэх хангах энэ тал дээр анхаарч ажиллаж байгаа. Дрон байхгүй биш бас байгаа тодорхой хэмжээнд байгаа. Цаашидаа өөр илүү бас энэ дроныг Монголдоо угсрах үйлдвэрлэх өөрсдөө илүү хангах тал дээр та бүхэн бас бодлогын хувьд дэмжлэг үзүүлээд өгвөл бид бүхэн бас энэ чадавхаа бэхжүүлэх тал дээр манай боловсон хүчний болоод өөрсдөө хүртэл Дрон үйлдвэрлэсэн туршилага байна. Бидэнд бас угсарчих бололцоо. Энэ тал дээр та бүхэн бас дэмжлэг үзүүлээсэй гэж хүсэж байна аа.

Хоёр хөрш ч гэсэн бас дайны байдалтай бас амаргүй л байгаа. Орос Украйны дайн цаашилаад Хойд Солонгос оролцоод ингээд энэ дайн чинь улам өргөжих юм бол Оросын нутгийн гүн рүү цохилт өгөөд эхэлбэл юу болох вэ? Үүнтэй холбоотойгоор дүрвэгсэд ороод ирвэл юу болох вэ? Монгол улс руу. Бензин шатахууны хомсдол үүсэх цаашилаад эрчим хүчний тасалдал үүсэх гээд үүнээс болоод дотооддоо бас асуудал үүсвэл юу болох вэ? Энэ бас батлан хамгаалах хүч Зэвсэгт хүчин бас оролцож л таарна. Ер нь одоо ч гэсэн өнөөдөр бид нар бас ган зуд болоход, өвчин зовлон тохиолдоход, гал түймэр гарахад энэ бүхий л үед бас онцгой байдлын байгууллагадаа дэм болж бас манай батлан хамгаалах, зэвсэгт хүчин бол бүгдэд нь оролцдог ачааны хүндийг үүрдэг. Ачааны хөндийг үүрдэг. Та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн жил зуд болоход ерөөсөө л гол ачааг Зэвсэгт хүчнийхэн маань үүрсэн. Зуд болоход бас л

мөн хэдэн цэргүүд бас зуданд явдаг, гал түймэр гарахад. Иймэрхүү одоо бас нөхцөл байдалд тийм үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд манай энэ салбарыг бас бэхжүүлэх зайлшгүй шаардлага байгаа.

Энийг бас Ганбат гишүүн маань ойлгож байгаад бас баярлаж байна. Бас дэмжээд тодорхой саналууд гаргаад анхаараад өгөөсэй л гэж таны зүгээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Бид нар бол төсөв мөнгө ийм байгаа. Энэ тэр гэдгээ шалтаглаж болохгүй л дээ. Гэхдээ бид нарын зорилго өнөөдрийн нөхцөл байдлын шаардлага хуулийн хэрэгжилт гэдэг юм байна. Тэгэхээр зуны 3 сар өөр хавар намрын 1.5, 1.5 ингээд 6 сар бид нар энэ хүмүүсээ бэлтгэчихэж болох юм. Тэр талаар анхаарч ажиллах хэрэгтэй байна гэдгийг бас хэлье ээ. Тэгээд 18-аас 25 хүртэл насны алба татаж байна уу? Нийтдээ цэргийн алба хаах ёстой хэчнээн хэмжээний залуучууд байна вэ? Тэр тооцоо байгаа юу? Бас ер нь бол тэр улс ардын аж ахуйд хэрэгтэй шаардлагатай бол сүүлийн нэг сарыг нь бас энд тэнд ажиллуулж болно шүү дээ.

Байгалийн гамшигийн эсрэг тэмцэх энэ сургалтыг нь хамт явуулаад гэх мэтчилэнгийн бас одоо эрэлхийлэх хэрэгтэй байна л даа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Таны хэлж байгаа зөв өө. Бид нар бас цэргийн эрдэмд суралцахаас гадна хажуугаар нь тийм үү бас нэг амьдрах ухаанд дээрээс нь бас амьдралаа аваад байх амьжиргаатай болох байдлаар тэр англи хэлний анхан шатны мэдлэгтэй болгох, мэдээллийн технологи, компьютерын мэдлэгтэй болгох, жолооны курст сурах. Цаашилаад

бид нар бас барилгын цэргийн ангиуд дээрээ Барилгачин, шаварчин, өрлөгчин гээд бас давхар мэргэжил эзэмших, мөн одоо бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрт оролцох, ойчин цэрэг мөн одоо бас модноос гадна туслах аж ахуйг хөгжүүлээд хажуу талдаа бид бас орлого олох бололцоо бүрдүүлэх. Энэ чиглэлээрээ бид нар бас ногоо тарих, газар тариаланд бас оролцох ийм байдлаар цэргийн эрдэмд суралцахын хажуугаар давхар мэргэжилтэй болох, давхар бас амьжиргаагаа олоод явчих ийм чадвартай болгох байдлаар бас цэргийн албан хаагчдыг сонирхолтой болгох тал дээр тодорхой хөтөлбөрүүдийг нэмж сургалтын хөтөлбөрт нь оруулж байгаа.

Тэгээд түүнтэй холбоотойгоор юу гэдэг юм цэргийн алба хаах хугацааг багасгах бололцоо, боломж бага байгаа. Давхар мэргэжилтэй болж байгаа учраас. Нэг жилийн хугацаанд бас суралцаасай гэж хүсэж байгаа. Тэр цэргийн албан хаагчдын.

Г.Тэмүүлэн: Бямбацогт сайдад минут нэмж өгье.

С.Бямбацогт: Ийм байдлаар үндсэндээ цаашидаа бол бас батлан хамгаалах, аж үйлдвэр, төрийн салбарыг бас хөгжүүлэх энэ талдаа бид бас илүү анхаарч ажиллана гэсэн ийм бодлого барьж байгаа. Энэ хүрээндээ бас тодорхой хэмжээгээр ирэх жилээс ингээд энэ оны төсөв дээр тодорхой хөрөнгө оруулалт тоног төхөөрөмжийг шийдэх шийдлүүд нь шийдэгдчихвэл бид нар ирэх жилээс үндсэндээ цэргийн алба хааж байгаа албан хаагчдаа англи хэл, мөн компьютер мөн бас жолооны курсээ цаашидаа бусад бас нийгэмд эрэлттэй мэргэжлүүдээр давхар мэргэжил эзэмшээд амьдралд гараад бэлтгэгдээд явах бас бололцоо боломжийг нь бүрдүүлсэн ийм бас болгох бололцоотой. Ийм боломжийг бүрдүүлнэ гэж харж байгаа.

Тийм болохоор цэргийн өөрийнх нь бас нэг хөтөлбөр байж байгаа. Сургалтын хөтөлбөр. Тэр хөтөлбөрт заагдсан бас цэргийн эрдэмдээ суралцах ёстой.

Тийм болохоор түүнтэй холбоотойгоор нөгөө юуг хугацааг богиносгох бололцоогүй цэргийн алба хаах насны тоо Ганхуяг дарга хариулчих.

Г.Тэмүүлэн: Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг дарга. 9 номер асуултад нэмж хариулъя.

Д.Ганхуяг: Ганбат гишүүний асуултад хариулъя. БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга. Энэ жилийн цэрэг татлага бол 74 хувьтай явж байгаа. Энэ жилийн онцлог бол бид аймаг нийслэл, өөрсдөө бас эрүүл мэндийн нэгдлээрээ эрүүл мэндийн үзлэгийг хийж байгаа. Ер нь жилд бол ойролцоогоор хориод мянган залуучууд байгаа. 18-аас 25 насны. Үүнээс бид хэд одоо тодорхой тоо буюу батлагдсан тооныхоо хүрээнд 4 мянга орчим цэрэг татаж сургадаг. Бид мөн оюутан цэргийг 500 анх бол 500 хүнтэй эхэлж байсан бол одоо мянга болсон. Ирэх оны төсөвт 3 мянган хүн хүртэл сураглаж бэлтгэхээр төлөвлөж байгаа. Оюутан цэрэг маань энэ сургалтад хамрагдсаны дараа бол цэргийн 1 дүгээр бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдээд үүрэг гүйцэтгэхэд.

Г.Тэмүүлэн: 9 номер нэмээд микрофон өгье. Хариултаа гүйцээгээд хариулаарай.

Д.Ганхуяг: Хуулиараа бол 18-аас 25 насны залуучуудыг л татаж байгаа. 26 хүрээд ирэхээрээ мөнгөн хэлбэрээр хаах, дүйцүүлэн хаах ингээд цэргийн үүрэгтнээр бүртгэгдээд явдаг. 18-аас 25 бол хууль дээр заасан биеэр энэ насны эрүүл чийрэг залуучууд бол цэргийн алба хаах ийм үүрэгтэй хуулийн дагуу.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя.

Үндэсний кибер аюулгүй байдлын индексээр Монгол Улс 126-д, 18.8 оноогоор нэн өндөр эрсдэлтэй улсын тоонд орчихсон явж байгаа. БХЯ-ны кибер аюулгүй байдал Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцахад БХЯ-ны салбарын аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн лицензийн төлбөр 2023 оны нэг сард дууссан. Шийдвэрлэж өгөөч ээ гэсэн хүсэлт тавьсан. Энэ дээр манай Байнгын хороо ажиллаж байгаа.

Гэтэл 2025 оны төсөв дээр энэ асуудлаа тусгаагүй орж ирсэн байна аа. Энэ асуудлыг хэрхэн яаж тусгаж оруулж ирэх вэ гэдэг нэг асуултыг асууя. Шийдвэрлэх арга зам нь юу юм? Төсөвтөө тусгаагүй. Тэгэхдээ энийг шийдвэрлэж өгөөч гээд байдаг.

Хоёрдугаарт, Төсвийн төслийн 1 дүгээр хавсралт дахь 2025 оны төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн чанарын тоо хэмжээний үзүүлэлтээр Батлан хамгаалахын сайдын хүрэх үр дүн хэсэг ганцхан заалттай байгаа. Энэ нь өөрөөр хэлбэл 27.1 дүгээр заалт.

Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ гээд болчихсон. Аягүй ерөнхий заалт байна. Энэ нь дараа нь өөрөө Аудитын газар ажлын чанар үр дүнг хэлэлцэх аргагүй яаж хэмжих юм бэ? Энэ ерөнхий ажлууд орсон байна. Энийгээ бид нар Төсвийн тухай хуульдаа санал оруулж засах ёстой юм биш үү?

Хоёрдугаарт яг энэнтэй уялдуулаад Сангийн сайдаас бас нэг асуулт асуумаар байна. Монгол Улсын төсвийн гүйцэтгэлүүдийг төсвийн зарцуулалтаар нь дүгнээд байна. Ерөнхийдөө ингээд харахаар гарсан зарцуулалт тавигдсан төсөвт нь гүйцэтгэл нь 70 юм уу 60 хувьтай байхад төсвийн зарцуулалт нь 100 тэрбум гэж

заагаад 100 тэрбум гарсан бол 100 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэдэг нэг нийтлэг шинж чанар ажиглагдаад байгаа юм. Энийг хэзээ яаж засаж залруулах вэ? Аудитын газрын дүгнэлтэд нь өөрөө аудит хийж байгаа газруудад нь материалаа дутуу өгснөөс болоод аудитын дүгнэлтийг бүрэн гаргах бололцоогүй гэсэн төслүүд байгаа. Гэтэл тэрэн дээр нь дараа жилийн төсөвт нь дахиад нэмэлт төсөвт тусгагдаад яваад байх юм. Тэрийг ямар үр дүнгээр нь хэмжиж төсвийг нэмж өгөөд байгаа юм бэ гэдэг асуултыг асууя. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тэгэхээр 2025 оны төсөв төлөвлөгөөн дээр бас зорилтот түвшин 50 хувь гээд тавьсан байна аа. Ганцхан хэмжих үзүүлэлттэй ганцхан асуултаар тавьсан байж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах салбартай холбоотой үндсэндээ 10 зорилт орсон байгаа. Мааш тодорхой. Тэгээд энэ 10 зорилтоо л бид хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Тогтвортой хүртээмжтэй төсөв Монгол эр цэргийг мөн гадаадад бас энхийг сахиулах ажиллагаанд оролцох барих гээд л эх оронч үзлийг төлөвшүүлэх гэсэн ерөнхийдөө 1 тийм. Энэ дотроос гол анхаарах юм бол бид нар үндэсний энэ сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд бол зайлигүй бас онцгой анхаарч ажиллах ёстой.

Ингээд энэ тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхэд хуваарилагдаж байгаа төсөв маань урьд өмнөх жилүүдтэй харьцуулах юм бол харьцангуй бас нэмэгдсэн. Сангийн яамныхандаа бас баярлаж байгаа.

Гэхдээ яг бидний өмнөө тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд бол түрүүн би хэлсэн 100 хувь гэж үзэх юм бол дөнгөж 5 хувийг нь хэрэгжүүлэх хэмжээний төсөв л хуваарилагдаж байгаа төсөв дээр. Тийм болохоор бас л юу гэдэг юм өмнөө тавьсан

зорилтоо хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний төсөв санхүү бидэнд байхгүй байгаа. Хэдийгээр урьд өмнөхтэй харьцуулахад өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдэж байгаа ч гэсэн. Түүний нэг нь таны сая хэлж байгаа тэр кибер манай цэрэг байдаг салбар. Энд бас шаардлагатай ашиглаж байгаа программ хангамжуудын лицензийн төлбөр гэдэг асуудлыг бид нар шийдэж чадаагүй л явж байгаа. Шийдэх маш олон асуудлууд байгаа. Шийдэх олон асуудлаасаа тодорхой тодорхой хэмжээнд шийдээд явж байна. Хугацаат цэргийн албан хаагчдын жишээ нь одоо хөнжил гудас, тэгээд л нөгөө хөнжлийн даавуу дэвсээ, бүтээлэг, шүүгээ зэрэг асуудлыг урьд нь шийдэж чадаагүй байсан бол Сангийн яамтай ярьж байж бид нар өөр зардлаасаа ч зориулалтыг нь өөрчилж байж энэ жил шийдсэн. Өнөөдөр цэргийн ангийн захирагч нар үндсэндээ унаж байгаа машин байхгүй байгаа. 1985 онд үйлдвэрлэгдсэн Герман машинтай эс үгүй бол 2000 оны эхээр үйлдвэрлэгдсэн УАЗ 469 машинтай өөр явдаг машин байхгүй болсон. Цэргийн ангийн захирагч нар үүнийхээ тодорхой хувийг л бид нар шийдэх гээд оролдож байгаа. Барилга байшингийн тухайд бас түрүүн би бас ярилаа.

Ерөөсөө ихэнх байшин гэхэд ашиглалтын хугацаа дуусчихсан ийм байшингуудтай болчихсон бөөн бороо шороо ордог. Дээвэр нь цоорхой онгорхой нэг иймэрхүү байдалтай байгаад байгаа. Үүнийх нь тодорхой хувийг их засвар тодорхой бүгдийг нь биш тодорхой хувийг нь шийдэх гээд мөнгө тавьсан. Иймэрхүү байдлаар нэн тулгамдсан асуудлуудаасаа эхлээд ингээд бүгдийг нь биш тодорхой хувийг нь шийдэх гээд ингээд урьд жилтэй харьцуулбал харьцангуй ахиулж мөнгө тавигдсан ч гэсэн хүрэлцэхгүй байгаад байгаа юм аа.

Энийг та бүхэн бас ойлгоосой. Тийм болохоор манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Цахим бодлогын байнгын хорооныхон бас манай

Кибер цэргийнхний үйл ажиллагаатай танилцсан юм байна лээ. Тэгээд энэ үед бас асуудал яригдсан юм байна лээ. Бас тэгээд энийг бас шийдэх шийдэл байвал төсвийн ажлын хэсэг, Байнгын хороо бас нэг анхааралдаа аваад өгөөсэй л гэж та бүгдээс бас хүсье дээ.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Анар гишүүний асуултад нэмж хариулъя аа. Анар гишүүн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилт ямар процессоор явдаг вэ? Энэ дээр урьд өмнө нь гарч байгаа асуудлууд байна гэж байна. Энэ талаар тодруулж мэдээлэл өгье.

Төсвийн хөрөнгө оруулалт дээр төсвийн захиалагч гүйцэтгэгч аж ахуйн нэгж ингээд төрийн сан гэсэн ийм 3 харилцаанд орж төсвийн бүрэлдэхүүн хэсэг байдаг. Ингээд захиалагч яам нь одоо жишээ нь Боловсролын яам, сургууль захиаллаа гэхэд гүйцэтгэгч компанитай гэрээгээ хийгээд ингээд жилийн гүйцэтгэлийн явцад гүйцэтгэлийн тайланг нь аваад тэрийг нь баталгаажуулаад энэ дүнтэй мөнгөнд таарсан ажил хийсэн байна. Энэ мөнгийг нь өгье өө, олгоё гээд энийгээ баталгаажуулаад үндсэндээ тэр таны хэлсэн сайн аудитыг хийлгүүлээд төрийн санд ирүүлдэг. Тэрнийх нь дагуу Төрийн сан бичиг баримтын бүрдлийг нь үзээд санхүүжилтээ хийгээд явдаг юм байгаа юм. Харин үнийн одоо нэмэгдэл болон.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдын минутыг нэмээд өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр үнийн өсөлт гэж зүйл сүүлийн жилүүдэд маш огцом яригдаж байгаа. Энэ дээр одоо 2 үндсэн шалтгаан байна.

Нэгдүгээрт яах аргагүй сая энэ ковидын үед дэлхий нийтээрээ үнийн өсөлтөд нэрвэгдлээ. Энэтэй холбоотой зайлшгүй одоо нэмэгдэх асуудлууд гарч ирсэн.

Хоёр дахь асуудал хамгийн том дутагдалтай асуудал бол одоо энэ төсөвт бэлтгэл ажил нь дутуу хангагдсан. Өөрөөр хэлбэл хуучин зураг төсөвтөө эсвэл зураг төсөв нь хийгдээгүй ТЭЗҮ нь ч хийгдээгүй магадлангаар ороогүй ийм төслүүд ордог байснаас болж ингээд гүйцэтгэлийн явцад үнийн өсөлтүүд нь гарч ирдэг энэ байдлыг бол хуулиар бүрэн зогсоосон байгаа. Энэ дотор бол бүр нэг ийм хатуу заалт байгаа. Магадлан хийгдсэн төсөв нь сүүлийн 2 жилийн хугацаанд хийсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл одоо энэ 2024 оны 9 сарын 1-нд өргөн баригдаж байгаа бүх төслүүд 2022 оны 9 сарын 1-ээс хойш хийгдсэн магадлантай байх ёстой. Энэнээс өмнө бол.

Г.Тэмүүлэн: Дуусгачихъя Жавхлан сайд хариултаа нэмээд өгье.

Б.Жавхлан: Тусгаж болохгүй ийм заалттай. Тийм учраас энийг одоо Засгийн газар дээр ч тэр Улсын Их Хурал дээр ч тэр төсвийг хэлэлцэж батлахдаа онцгой анхаарна гэж ингэж бид үзэж байгаа. Тэгээд энэ үнийн өсөлт энэ магадланг хийдэг ерөөсөө эрх бүхий тийм ерөөсөө гуравхан институт байдаг. Барилгын яамны дэргэд Барилгын хөгжлийн төв, ЗТЯ-ны дэргэд Зам тээврийн хөгжлийн төв, ЭХЯ-ны дэргэд Эрчим хүчний хөгжлийн төв гээд ингээд төрийн албан хаагч нар биш тусгай зөвшөөрөл бүхий экспертүүд тэнд суугаад энэ магадланг хараат бус байдлаар хийдэг юм байгаа юм. Эндээс ерөөсөө төрийн албан хаагч нар болон төрийн захиргааны байгууллагууд ерөөсөө огт оролцдоггүй. Тэндээс магадлан ирсэн. Тэгээд л захиалагч яам нь энэ үнийн өсөлтийг хийхгүй л бол энэ төсөл зогсох ийм эрсдэлд орлоо гэдэг ийм үндэслэлээр мөн Төсвийн хуулийн дагуу бусад заалтуудын дагуу орох эсэх нь ингээд шийдэгдээд явдаг. Мөн сүүлийн жилүүдэд бол бид нар нэг давхар нэг шат нэмсэн нь бол Аудитын Ерөнхий газар өгч давхар аудитлуулж байгаа ийм

процессоор бид бат баталгаажуулж явж байгаа гэсэн үг.

Тийм учраас цаашидаа одоо энд дутагдлыг арилгах хамгийн гол зүйл бол ерөөсөө хуулиа л дагах, өөрөөр хэлбэл сүүлийн 2 жил хийгдсэн магадлантай зураг төсөлтэй ийм л зүйлүүдийг төсөвт тусгаж явах нь цаашидаа одоо энэ эрсдэлийг хаана гэж үзэж байгаа.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд өнөөдөр манай Байнгын хорооны харьяалах байгууллагуудын төсөв дээрээс би Батлан хамгаалахын яамнаас онцгойлон асуулт асууя гэж бодож байна. Энэ жилийн төсөв нэмэгдсэн энэ зардлын өсөлтөөрөө харахад бол хамгийн өндөр хэмжээгээр нэмэгдсэн буюу 110 хувиар нийтдээ 20 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн хэсэгт эд хогшил, урсгал засварын зардал гэсэн ийм хэсэг байна. Эндээс сая сайдын хариултаа сонсоход цэргүүдийн англи хэлний сургалт, жолооны курс гэх мэтчилэн эдгээр мэргэжлийн боловсрол олгох асуудал дээр энийг орж байна гэж ойлгож байна л даа.

Тэгэхээр би эндээс нэг юм тодруулах гээд байгаа нь төр одоо өөрөө бараг жолооны курс ажиллуулаад эхэлнэ гэсэн үг үү? Англи хэлний багш нар Батлан хамгаалахын яам авна гэсэн үг үү? Энийгээ гүйцэтгүүлэхдээ хувийн хэвшилтэйгээ өрсөлдсөн бус хувийн хэвшлийгээ татан оролцуулах ийм боломжийг харж байгаа юу? Эсвэл энэ 20 тэрбум төгрөгөөр БХЯ машинууд аваад л жолооны курс ажиллуулаад байна гэсэн үг үү гэдэг дээр тодруулах асуулт байна.

ГХЯ-ны төсөв дээрээс бас нэг зүйлийг тодруулах гэсэн юм.

Нэлээд бас зардал нь өсөж байгаа хэсэг НҮБ-ын суурь конвенцын талуудын 17 дугаар конвенцын хурал байгаа. Энийг

Монгол Улс зохион байгуулж байгаа нь их сайшаалтай гэж үзэж байгаа. Цөлжилтийн эсрэг энэ конвенцыг. Энэ дээр зардлууд хамгийн ихэссэн хэсэг мөн энэ хуралтай холбоотой учир өмнөх Асемын туршилагаас харахад ч юм уу та бүхэн энэ зардлыг хэрхэн зөв зохистой Төсвийн хуулийн дагуу гаргах энэ тэр дээр цаг хугацаагаа сайн төлөвлөж байгаа юу? Жишээлж харахад энэ төсвийн ном дээр болохоор энэ бага хурлын байгууламжийн барилга угсралтад 50 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Гэтэл энэ ГХЯ-ны төсөв дээр байхгүй байна л даа. Тэгэхээр энэ хаана тусгагдсан юм. Энэ яг хурлаа амжилттай зохион байгуулахын тулд нөгөө бичгийн асуудал, төсвийн зардал, гүйлгээ энэ тэр дээр алдаа гарах вий гэдэг үүднээс энийг асууж байгаа юм шүү.

Тэгэхээр энэ дээр Гадаад харилцааны яамнаас асууя гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Бямбацогт сайд асуултад хариулъя.

С.Бямбацогт: Болормаа гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр энэ хугацаат цэргийн албан хаагчдыг бид нар англи хэлний болон компьютерын анхан шатны мэдлэгтэй, жолооны үнэмлэхтэй болгоход өөрсдийнхөө дотоод нөөц бололцоогоо ихэвчлэн дайчилж ашиглана аа.

Өөрөөр хэлэх юм бол бас манай Зэвсэгт хүчний анги салбаруудад ажиллаж байгаа цэргийн албан хаагч нар бас энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа. Ингэхдээ тодорхой хэмжээний бас хэлний бэлтгэлд суудаг, хэл сурдаг. Ингээд хэлтэй бас боловсон хүчин манайд бас байна. Мөн бас Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль дээр бас Англи хэлтэй бас боловсон хүчнээ бид нар бэлддэг. Үүнээс гадна одоо 2, 3 цэргийн анги дээр тусгайлсан яг яг зориулалтын англи хэлний бас анхан,

дунд, гүнзгийрүүлсэн шатны бас дамжаанууд бид нар хичээллүүлж байгаа. Энд бэлдэж байгаа боловсон хүчнүүдээрээ бид нар англи хэлний сургалтуудыг зохион байгуулах мөн компьютерын анхан шатны мэдлэг олгох энэ сургалтуудыг бас яг яг үүнтэй адилхан Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль болон бусад бас офицер ахлагч нараар би мэргэжлийн улсуудаар сургах ийм бас бодлого барина. Жолооны курс жолоочийн тухайд бол бид нар ганц 2 анги маань үндсэндээ бас дотооддоо бас боловсон хүчнээ бас бэлддэг жолооч бэлдэх ийм мэргэжлийн. Түүнээс гадна одоо бол энэ бусад нөгөө хувийн хэвшлийн байгууллага жолооны курсүүдтэйгээ хамтарч ажиллаж тэдэнтэй хамтарч тэднээр дамжуулж бэлтгэх ийм бас байдлаар шийдэх гэж байгаа. Урьд нь ч бас шийдээд явж байсан бас туршилага байгаа. Ингэхдээ бол хугацаат цэргийн албан хаагчдын ар гэр нь зөвшөөрвөл ар гэрээс нь тодорхой төлбөрийг нь гаргаж бас жолооны курст сургах ийм бас асуудлыг шийдэж байсан бас жишиг туршилага байгаа. Одоо яг үүнийгээ үргэлжлүүлээд ингээд хувийн хэвлэлийн жолооны курсүүдтэй тодорхой хувьд хамтарч ажиллана. Өөрсдөө бас өөрсдийнхөө хуучин бэлдэж байгаа ангиуд дээрээ бас үргэлжлүүлж бэлдэх, ийм байдлаар бэлдэх юм аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайд асуултад нэмж хариулъя. Батцэцэг сайдын микрофон.

Б.Батцэцэг: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Болормаа гишүүний асуултад хариулъя.

Говь баруун долоо гээд цөлжилттэй тэмцэх тухайн НҮБ-ын суурь конвенцуудын 17 дугаар бага хурлыг Монголд зохион байгуулахаар шийдсэн. Энэ гол ажлыг бол Байгаль орчны яам зохион байгуулна. Гадаад харилцааны яам бол хамтарч зохион байгуулна. Тэгээд төсөв 50 тэрбум төгрөгийг Байгаль орчны яамны багц дээр суулгасан байгаа.

Манай хувьд болохоор Засгийн газрын шийдвэрээр ажлын алба байгуулагдсан. Манай Олон талт хамтын ажиллагааны газар дээр тулгуурлаад ажлын албыг байгуулаад холбогдох яамдууд бас албан хаагчид нийлээд ингээд үйл ажиллагаагаа эхэлчихсэн. НҮБ-тай энэ 3 жилийн хугацаанд бэлтгэл ажлаа хангаад ажиллах юм. Тэгээд бэлтгэл ажил бол эхэлчихсэн. НҮБ-ын энэ хурал зохион байгуулах баг бас хэд хэдэн удаа ирээд ажилласан байгаа. Тэгээд олон нэлээд ийм өндөр зардалтай. Тэгээд энэ 2026 онд болно. Энэ үеэр 7-оос 9 мянган хүн тэр дунд, доод, ахисан түвшний одоо яг энэ цөлжилттэй, байгаль орчинтой байгаль орчны чиглэлээрх мэргэжилтнүүд, судлаачид, эрдэмтэд маш олон хүн Монголд ирэх юм байна лээ. Тэгээд энэнтэй холбоотой нэлээд их ийм зардал гарахаар байгаа.

Манай яамны төсөв дээр бол нийтдээ 22 тэрбум 802 сая төгрөгийг төсөвлөсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад ингээд нэмэлт мэдээлэл өгье. Тэр олон улсын форум бол нэлээн том форум болдог. Манай улсын нүүр царайг ч илэрхийлэх чухал ач холбогдолтой ийм зүйл. 4 жилийн хөтөлбөр дотор ч мөн орчихсон ингээд явж байгаа. Ингээд Байгаль орчны сайд дээр ирэх жилийн төсөв дээр нь 50 тэрбум төгрөгөөр бэлтгэл ажлаа дөнгөж эхлүүлэх ийм хөрөнгө оруулалт тавигдсан боловч сая энэ Байнгын хороод дээр хэлэлцүүлэх шатад ХЗБХ-н дээр 15 тэрбум төгрөгөөр танах зарчмын зөрүүтэй санал гараад тэнд ингээд дэмжигдчихнэ лээ. Тэгээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд бас энийг анхаарна биз ээ. Төсвийн хэлэлцүүлэг дээр.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүнийг ирж тодруулъя.

Э.Болормаа: Баярлалаа. Батлан хамгаалахын сайдаас тодруулах гэсэн юм тэгэхээр ер нь нэлээд дотоод нөөц бололцоо дээрээ тулгуурлаж энэ сургалтуудыг явуулна гэж ойлгож байгаа бол энэ эд хогшил урсгал засварын зардал буюу хамгийн өндөр өсөлттэй байгаа 2 дахин их гэсэн үг шүү дээ 110 хувийн өсөлттэй байгаа. Энэ яг юунд зарцуулагдаж байгаа вэ? Хэрвээ дотоод нөөц бололцоогоосоо хийх гэж байгаа бол энэ 20 тэрбум төгрөг яг юунд зарцуулж байгаа бол?

Г.Тэмүүлэн: Ганхуяг дарга хариулах уу? 9 номер.

Д.Ганхуяг: Гишүүний асуултад хариулъя.

Бид сургалтын хөтөлбөртөө ишинэчлээд дотоод нөөц бололцоогоороо англи хэл заах, компьютерын мэдлэг олгох, дээр нь жолооны курст хамруулах бусад шаардлагатай тохиолдолд орон нутгийн МСҮТ-тэй хамтарч оператор гэх мэргэжлүүдээр мэргэжлийг эзэмшүүлнэ. Энэ дотоод нөөц бололцоогоо жолооны курсийн хувьд бол бид бол дотроо бололцоо багатай. Тийм учраас ААН-тэйгээ харилцан ажиллагаа төрийн ажлыг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх энэ хүрээнд гэрээ байгуулж ажиллая гэж төлөвлөж байгаа. Ер нь энэ урсгал зардлын төсвийг харахад 2023 онд бид зөвхөн 1.4 тэрбум төгрөг л батлагдаж байсан. Ер нь бол энэ БХЯ-ан дээр бол төвлөрөөд байдаг төсөв байхгүй. Энэ бол зэвсэгт хүчний хэмжээнд зэвсэгт хүчинд ойролцоогоор.

Г.Тэмүүлэн: 9 номер нэмээд хариулъя.

Д.Ганхуяг: Ер нь бол ингээд Зэвсэгт хүчинд ерээд нэгж байгаа. Хамгийн цөөхөн хүнтэй нэгж бол 100 хүнтэй. Тэр анги байгууллагын байришилд дор хаяж 30-аас 40 ийм объектууд байгаа. Энэ объектуудын засвар мөн зарим хэсэг нь сургалтын материаллаг

баазыг бэхжүүлэхийн тулд энэ эд хогшил сандал ширээ ийм зүйлүүдэд зарцуулна. Тэгээд яалт ч үгүй засвар хийх, үйлчилгээ хийх объект нь ийм том учраас ингээж өндөр өсөлттэй гарч байгаа. 2023 онд 1.3, 2025 онд 37 тэрбумаар ийм юм явж байгаа.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Би зүгээр дараа нь тусдаа бас авбал бас болно. Зүгээр энэ 20 тэрбум дээрээ та бүхэн ар тал дээрээ тайлбар дээрээ зүгээр ийм МСҮТ-д юм шиг биччихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ барилга байгууламжийн засвар гэдгээ маш тодорхой оруулчихвал энэ нь илүү ойлгомжтой болов уу. Тэгэхгүй бол эндээс харах юм бол яг энэ заасан дээр байгаагаараа бол энэ цэргийн албан хаагчдынхаа мэргэжлийн боловсрол олгоход ингээд Данхайгаад төр өөрөө хийх гээд байгаа юм шиг л харагдаад байна. Тэгэхээр энийгээ тодруулчихвал илүү ойлгомжтой болох болов уу. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Сайн байцаана уу? Гадаад харилцааны сайдаас асуух гэсэн юм. Тэгээд өнгөрсөн хугацаанд бид гадаад харилцааг эдийн засагжуулах гэдэг бас нэр томъёог их олон жил бас ярьсан. Тэгээд манай бас гадаад харилцаан дээр энэ эдийн засгийн ач холбогдолтой зүйлүүд хэр явж байна? Дипломат төлөөлөгчийн газруудын шинэ зах зээл эрэлхийлэх Монголын бас дотоодын ААН-үүдийн экспортод зориулсан тийм зах зээлүүдийг нээж олох, зуучлах энэ чиглэлээр бас ямар ажил хийж байна гэдэг тал дээр бас нэг асуулт байгаад байгаа юм.

Яагаад вэ гэхлээр ер нь бидний хувьд экспортын гол түүхий эд маань бол одоо уул уурхайн түүхий эдүүд байж байна. Тэгээд экспортын голлох түнш

маань бол бас нэг улс орон байж байна. Тэгэхээр энэ утгаараа гадаад харилцааны өнцгөөс аюулгүй байдлын өнцгөөсөө ч тэр бас олон улсад уул уурхайн бус түүхий эдийн илүү тийм солонгорсон зах зээлүүдийг эрэлхийлэх нь чухал байна. Тэгэхээр энэ дээр манай бас дипломат төлөөлөгчийн газрууд, Дипломат төлөөлөгчийн газарт томилогдсон эдийн засгийн зөвлөхүүд ч гэдэг юм уу энэ чиглэлээр ер нь ямар ажил төлөвлөж байна ирэх жилийн төсөвт бас тодорхой асуудлууд суусан байгаа юу? Цаашид энэ чиглэлээр бас нэлээн тийм идэвх санаачилгатай ажиллах нь зөв зүйтэй гэсэн ийм бодолтой байгаа учраас асууж байгаа юм аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүний асуултад Батцэцэг сайд хариулъя. Батцэцэг сайд.

Б.Жаргалан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Баярлалаа.

Тэгээд өнөөдөр Монгол Улс яах вэ нэг үеэ бодвол бас дипломат төлөөлөгчийн газруудыг бага зэрэг чадавхжих тал руугаа явж байгаа. Нийтдээ манайд өнөөдөр 49 оронд дипломат төлөөлөгчийн газар байна. ЭСЯ, Ерөнхий консулын газар, Консулын газар 2 газар Худалдааны төлөөлөгчийн газар ажиллаж байгаа. Орон тоо маш бага байсан. Нэг дипломат маш олон төрлийн ажил хийдэг. Эдийн засгийн агуулгаараа худалдааны чиглэлийн ч юм уу бизнесийн мэдлэгтэй хүмүүс их ховор байсан. Хуучин бол голдуу улс төрийн харилцаа хийдэг байсан. Сүүлийн жилүүдэд Сангийн яамнаас бас томилгоонууд дээр нэлээн чанаржиж байгаа. Бас худалдааны чиглэлээр эдийн засгийн мэдлэгтэй, англи хэл сайтай, гадаад хэл тухайн орныхоо хэлийг эзэмшсэн ийм хүмүүс томилгоонд нэмэгдэж явж байгаа.

Зүгээр цаашидаа Эдийн засгийн хөгжлийн яам байгуулсантай холбоотойгоор Эдийн засгийн хөгжлийн

яам ч гэсэн саналаа хэлээд манайд бас мэргэжлийн хүмүүс ажиллуулъя гэдэг зүйлийг ярьж байгаа. Элчин сайдууд ЭСЯ-дуудын хувьд сүүлийн 4 жилийн хугацаанд 30 гаран Элчин сайд томилогдсон. Элчин сайд нартай шинээр гэрээ байгуулж явахдаа ерөөсөө энэ эдийн засгийн агуулгаар нь харилцаагаа баяжуулах дотоодынхоо компаниудын үйл ажиллагааг дэмжих, иргэдийн асуудалд онцгойлон анхаарах гэдэг ийм зүйлүүд дээр нэлээн нарийн заалтуудтай тохирсон. Тэгээд мэдээж Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын ААН-үүд өөрсдөө бас захиалга зөв мэдээлэлтэй байх хэрэгтэй. Өөрсдөө ЭСЯ-дууд гадаад улс оронтой харьцах гэж байгаа даалгавраа тодорхой өгдөг байх хэрэгтэй. Тухайн оронтой харьцах талаар мэдээлэл шаарддаг байх гэх мэтээр 2 талын ажиллагаа бол цаашидаа илүү идэвхтэй байх ийм шаардлага үүсэж байгаа юм.

ЭСЯ-дын хувьд бол Элчин сайдууд маань энэ утгаар нь харилцааг хөгжүүлэхэд бэлэн холбогдох бүх төрийн байгууллагуудтай нь холбоо хэлхээ тогтоогоод олон төрлийн баримт бичгүүдийг сүүлийн 4 жил байгуулсан. Энэ эдийн засгийн чиглэлийн үүд хаалгаа нээх эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр нэлээдгүй ажлыг хийсэн. Энэ олон айлчлалын ард бол маш олон хэлэлцээрүүд, жишээлбэл агаарын харилцааны тухай хэлэлцээр визээс харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр, авто тээврийн хэлэлцээр, худалдааг хөнгөвчлөх, худалдаа, эдийн засгийн нөхцөлөө хөнгөрүүлэх чиглэлийн баримт бичгүүдийг хангалттай байгуулсан.

Одоо энийгээ ашиглах нь өөрөө Засгийн газрын бас нэг том сорилт байгаа.

Хоёрдугаарт манай ААН-үүдэд ч гэсэн яг манай ЭСЯ-дад тодорхой асуудлаар хандахад ахиц дэвшил зөндөө гарсан байгаа. Мэдээж энэ олон 30 гаруй Элчин сайд нар дотор бид нар жил болгон

тайланг авч Их Хурлын гишүүддээ бас хүргэж байя гэдэг ийм даалгаврыг авсан. Өнгөрсөн жилээс эхлээд бид нар 6 сар тутамд бас ажлыг нь дүгнээд эдийн засгийн агуулгаар нь бид нар ямар ажил үүрэг хийв гэдгийг нь дүгнээд явснаас хойш тодорхой ахиц гарч байгаа. Тэгээд л дэлгэрэнгүй мэдээллийг бас гишүүдэд бас өгөх ийм боломжтой байгаа.

Тэгээд гишүүдээсээ бас яг ийм тодорхой саналууд байвал бас бид нар уламжлаад Элчин сайд нартаа онлайн хурал зохион байгуулаад яг ийм бүтээлч санаачилгуудыг дэвшүүлж байна гэхэд бас их дуртай баяртай байх болно гэдгээ хэлье.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүн болсон тиймээ? Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Би Монгол Улсын Шадар сайдаас асуулт байна. Энд бол чөлөөт бүсийг хөгжүүлэх гээд байгаад байгаа. Баян-Өлгий аймаг Цагааннуурын чөлөөт бүс байгаа. Нэг хашаа татчихсан. Ямар ч ажил нь явдаггүй. Эндээс хараад байхад улсын төсөвт бас мөнгө төгрөг янз бүрийн юм суугаагүй байна. Нэг дэх асуудал.

Энэ чөлөөт бүс ер нь явах юм уу? Ямар бодлого барьж байгаа юм бэ? Энийг нэг талд нь шийдмээр байна явуулбал явуулаад л явуулахгүй бол өөр арга хэмжээ аваад.

Хоёрдугаарт, энэ Цагаан нуур тосгонд газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савнууд байгаа. Улсын нөөцөд харьяалагддаг гээд сонссон. Олон жил болсон тухайн үед баруун 5 аймгийг хангаж байсан тийм газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савнууд. Ер нь энийг бол бас нэг тийш нь болговол зүгээр юм биш үү? Байгаад байдаг ашиглаж

байгаа юм ч байхгүй. Энэ тал дээр хариулт авмаар байна аа.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам, Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд байна уу? Сайд байхгүй байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас хэн байна? Сайдыгаа дууд. Баярхүү дарга энэ байна. Та асуултад хариулчихъя. 3 номер дээр очоод асуултад хариулаарай.

3.Баярхүү: Сайн байна уу? Чөлөөт бүстэй холбоотой асуулт асуулаа гэж ойлголоо. Яг энэ асуудал дээр бид нар тодорхой хэмжээний мэдээлэл бэлтгэж танд тусгайлан хүргүүлэе гэсэн ийм бодолтой байна. Яг хариуцдаг Шадар сайдын зүгээс тодорхой хэмжээгээр мэдээллийг ирүүлэх байх гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Танай сайд, Төрийн нарийн хаана байгаа юм. 3 номер.

3.Баярхүү: Өнөөдөр бол Эдийн засаг хөгжлийн яамнаас нэрс бол ирээгүй байж байгаа. Маргаашийн байнгын хороонууд дээр бүгдээрээ суухаар байж байгаа.

Миний зүгээс яах вэ орон тоо болон бусад аюулгүй байдалтай холбоотой төслүүд дээр асуултууд ирвэл хариулъя гэсэн байдлаар ирсэн байгаа. Яг чөлөөт бүстэй холбоотой асуудлуудыг танд тусгайлан мэдээлэл бэлтгэж хүргүүлэе ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: Хоёр дахь асуулт Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савнууд. Энийг яах юм бэ?

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ? Эдийн засгийн хөгжлийн яам. Нөөцийн газар, ОБЕГ-аас хүн байна уу? Дэд дарга 3 номер.

Д.Намсрай: Цагаан нуур дээр улсын нөөцийн мэдэлд ямар ч сав байхгүй байгаа. Энэ хуучин байсан бол нэг компанийн мэдэлд байсан уу. Түүнээс биш манай байгууллагын мэдлийн сав огт байхгүй.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: Уг нь нөөцийн газарт байсан гэсэн юм даа. Социализмын үед баруун 5 аймгийг хангаж байсан томоохон нөөцийн савнууд байгаа. Яалт ч үгүй нөөцийн газарт байгаа юм даа. Тэгээд саваа мэдэхгүй хаана юу байгаагаа мэдэхгүй ингээд байж болох юм уу? Энэ савнуудыг эдийн засгийн эргэлтэд оруулаад газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савгүй болоод байна шүү дээ манай улс чинь. Тэгж хэрэглэж болдоггүй юм уу? Хариулт өгөх хүн байна уу?

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яамнаас хүн байхгүй байна. Очоод хариулчих тэгвэл 3 номер дээр.

3.Баярхүү: Таны асуудаг саяын асуултууд бүгд Амарсайхан сайдын буюу Шадар сайдтай холбоотой асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэнд дахиад хэлэхэд бол яг тэр газраас нь мэдээллийг нь аваад танд хүргүүлэе ээ. Яг чиглэлээрээ бол тэр Шадар сайд дээр бол асуудал нь байгаа гэж ойлгож байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо тэгээд Жангабыл гишүүнд холбогдох мэдээллүүдийг бас хүргүүлчээрэй. Жавхлан сайд нэмж тодруулах уу?

Б.Жавхлан: Гишүүний асуултад зүгээр нэмж мэдээлэл шүү. Ерөнхий мэдээлэл өгье. Ганц онцгой байдал эрхэлсэн сайд Шадар сайдын асуудал нь биш юм байгаа юм аа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудалд бас энэ нь хамаарч байгаа. Тэгээд Туваан сайд энэ дээр нэлээн онцгой анхаарч байгаа. Нэлээн дэлгэрэнгүй тодорхой мэдээлэл өгөх түвшинд ажил нь бас нэлээн явчихсан

байгаа. Бүсчилсэн энийг нөгөө бүсчилсэн хөгжлийнхөө загвартай холбоод тэр нөөцийн хуваарилалт гээд тэгээд энэ ганц шатахуун гэхгүй ер нь энэ нөөцийн хуваарилалтуудыгаа ингээд бүс бүсдээ төвлөрүүлэх таны ярьж байгаа тийм боломж байдаг бол бас анхааралд нь орсон байгаа болов уу гэж ингэж бодож байна. Ер нь нэлээн түлхүү бас ажил явчихсан байгаа шүү тэнд. Туваан сайд дээр.

Г.Тэмүүлэн: Ойлголоо баярлалаа.

Би нэг асуулт нэмээд нэг тодруулаад асуугаадахъя. Ер нь яах вэ зүгээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамаарах асуудлын хүрээнд гадаад улс орнууд болоод олон улсын байгууллагуудтай хийж байгаа зээлийн гэрээ хэлцлүүд хамаардаг. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо эцсийн шийдвэрийг бас гаргадаг. Нэг талдаа гадаад зээл тусламж болоод өрийн удирдлага мөн өрийн тогтвортой байдлын асуудлаар тодорхой хэмжээнд бас хариуцлага хүлээсэн Байнгын хороо байгаа.

Би энэ хүрээнд нэг талдаа нэг асуултыг асуух гээд байгаа зүйл бол сүүлийн жилүүдэд энэ Засгийн газрын өрийн үлдэгдэл бол жил ирэх тусам нэмэгдэж байна аа. Жил ирэх тусам нэмэгдэж байна. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр оруулж ирснээр аваад үзэх юм бол 2025 онд Засгийн газрын өрийн хэмжээ дээд түвшинээрээ гээд 52.2 их наяд болохоор байгаад л байгаа. 2 их наяд болохоор байгаа.

Тэгэхээр бид нар нэг талдаа энэ төсвийн эрсдэл болоод гадаад хүчин зүйлд өртөх эмзэг байдал бас хэвээр л байх гээд байгаа юм. Өөр илүү хүндрэх өшөө илүү өрийн тогтвортой бус байдал, өрийн харьцаа, дарамт нэмэгдэхээр байна гэж харагдаж байгаа юм. Тэгэхээр ирэх 4 жилийн хугацаанд ер нь Засгийн газрын өр ер нь яг ямар байх юм бэ? Хэр хугацаанд нэмэгдэх юм? Төсвийн хүрээнд төсөөлөл

дээр 2026, 2027 онуудад 52.3, 52.5 их наяд байна гэдэг юу байгаа юм? Тодорхой өсөлт байхгүйгээр. Зүгээр би энэ жилийн 2025 оны төсвийг оруулж ирж байгаа учраас 2026, 2027 оныхоо төсвийн хүрээний мэдэгдэл дээр нэг их өөрчлөлт оруулалгүй бараг 2025 онтойгоо адилхан байдлаар оруулж ирэв үү гэж бас хараад байгаа юм. Тийм хардах үндэслэл бас байна. Эргээд дахиад дараа оныхоо төсвийг орж ирэхээр 2026, 2027 оныхоо өөрийнхөө хэмжээгээ дахиад нэмээд ороод ирдэг. Ингээд жил болгон төсвийнхөө хүрээний мэдэгдлийг өөрчилдөг энэ нөхцөл байдал хэвшмэл шахуу болчихсон ийм ойлголт байгаа.

Тэгээд уг нь төсвийн хүрээний мэдэгдэл болоод энэ өрийн хэмжээ, өрийн удирдлагатай холбоотой асуудлууд бол нэг талдаа бас Эдийн засгийн хөгжлийн яаманд хамаарах асуудлууд байгаа. Энэ дээр яг ирэх жилүүдэд Засгийн газрын маань өрийн бодит байдал ер нь яг ямар хэмжээнд байх юм бэ? Зээлийн үйлчилгээний зардалтай бид нар ойролцоогоор 1 их наяд төгрөгийг явуулдаг. 1.2-оос 1.5 их наядыг сүүлийн жилүүдэд л байнгын зээлийн үйлчилгээний зардалд гаргаж байгаа. Ирэх 4 жилийн хугацаанд зээлийн үйлчилгээний зардал төсөв дээр ирээдүйд учрах дарамт нь өөрөө ямар байх юм бэ? Ирэх 4 жилийн хугацаанд. Энэ дээр ямар нэгэн баталгаа гаргах зүйл байна уу? Нэг талдаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бол энэ өрийн удирдлагатай холбоотой асуудлууд дээр хяналт тавих, тодорхой хэмжээнд хариуцлага үүрч байгаа өрийг хязгаарлах бодлогыг баримтлах энэ асуудал дээр бас онцгой ач холбогдол өгч анхаарал хандуулж ажиллах ёстой Байнгын хороо гэж харж байгаа.

Сангийн сайд бас энэ дээр нэмж хариулъя. Ер нь нэг талдаа бид нар бас нэрийн хатуу хязгаарыг өөрөө барьдаггүй, төсвийн сахилга бат сул байдаг энэ асуудлууд дээр бол онцгой анхаарч үзэх ёстой. Энэ дээр тайлбар хариулт авъя. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Тэмүүлэн даргын асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газар сүүлийн 5 жилийн хугацаанд гадаад өрийн стратеги дээрээ сул биш ер нь их нарийн чанга Их Хурлаас гаргасан шийдвэрийн хүрээнд энийгээ баримталж ирсэн байгаа. Тэрний үр дүнд ч бас эерэг үр дүнгүүд гарч байгаа. Энийг Улсын Их Хурлын гишүүд олон нийт маш сайн мэдэж байгаа. Бид зээлжих зэрэглэл ч бас сайжирлаа. Энэ бол бид өөрсдөө өгч байгаа үнэлгээ биш хөндлөнгийн аудитын үнэлгээ юм аа. Энэ ОУБ хөрөнгийн зах зээл дээрээс өгч байгаа үнэлгээ гэж хэлж болно.

Тоонууд дээр сүүлийн жилүүдэд бид тусгай шаардлагын хүрээнд ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийг үе шаттайгаар жил бүр буулгаж ирж байгаа хувь хэмжээ шүү. Ингээд ирэх жил Төсвийн хүрээний мэдэгдлийн тоог сая хэллээ. Ер нь бол хязгаар 60 гээд хууль дээрээ байгаа. Төсвийн хүрээн дээрээ бол энийгээ багасгаад 5 хувийн нөөцтэй орон зайтай орёе гээд 55 байгаа. 2025 оны гүйцэтгэл 42.6-тай байхаар бид төсвөө өргөн барьсан байгаа. Өөрөөр хэлбэл 42.6, 55 гэдэг маань энэний хооронд нэг дахиад 12 хувийн ийм нөөцтэй байна гэсэн үг. 2026, 2027 онуудад ч тэр мөн адил бид 10-15 хувийн нөөцтэй явахаар төлөвлөх нь эрсдэлгүй байх энэ зоондоо байна гэсэн үг.

Дээрээс нь бид дунд хугацааныхаа стратегийг 3, 3 жилээр батлаад явбал Улсын Их Хурал дээр батлуулаад явдаг байгаа. Хамгийн анхных нь 2019 онд батлагдаад, дараагийнх нь 2023 онд батлагдаад ирэх жил 2025 оны хавар 5 сард дараагийн 3 жилийнхийг Их Хурал батлах байгаа. Тэр хүрээнд ч гэсэн энэ асуудал нэлээн бас нарийн төлөвлөж яригдах учиртай ийм байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмэлт мэдээлэл өгөх юм уу? Асуусан байгаа.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн сайд нь бас алга байна, Төрийн нарийн бичгийн дарга нь алга байна. Асуудал хариуцсан газрын дарга нь бас байхгүй байна. Тэгэхээр Байнгын байнгын хороон дээр буюу хамаарах асуудал яригдах үед бас энэ дээр тодорхой тайлбар мэдээллүүдийг бас бэлдэж ирээрэй. Эдийн засгийн хөгжлийн яам.

Би нэмж тодруулж асуух гээд байгаа зүйл нь эргээд энэ улсын гадаад өрийн харьцаа, энэ ирэх 4 жилийн хугацаанд ер нь яг ямар байна гэсэн төлөвтэй байгаад байгаа юм. Яг гадаад өрийн харьцаа болон үндэсний нийт орлогод эзлэх хувь хэмжээ ямар байх юм? Гадаад өрийн харьцаа болон экспортод эзлэх хувь хэмжээ ямар байх юм? Гадаад өрийн харьцаа болон валютын нөөцийн эзлэх хувь хэмжээ ямар байх юм? Энэ асуудлууд дээр та хэд бас тодорхой мэдээллүүдийг бэлдэж тодорхой тайлбар мэдээллүүдийг бас Төсвийн байнгын хороон дээр өгөөрэй.

Нэг талдаа бас Эдийн засгийн хөгжлийн яаманд хамаарах асуудал энэ өрийн удирдлагын асуудал байгаа. Бид бүхний хувьд энэ бас төсвийн Засгийн газрын өрийн үлдэгдэл жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Энэ асуудал дээр бол онцгой анхаарал хандуулж, өрийн удирдлага менежментийг бас сайжруулах зайлигүй шаардлага бол байна. Өрийн хатуу хязгаарыг барьдаг байх, төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагыг сайжруулах шаардлага байгаа. Энэ дээр бас өөрсдийнхөө байр суурь бодлогоо бас танилцуул гэж хэлэх байна. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргаж саналаа тайлбарлан үг хэлэх гишүүд байгаа юу? Баярмаа гишүүн байна. Ганбат гишүүн кнопоо дараарай. Анар гишүүн бас байгаа. Наранбаатар Наранбаатар гишүүнээр тасаллаа.

Ганбат гишүүн. Анар гишүүн хамгийн сүүлд орсон. Анар гишүүнээр тасаллаа.

Д.Ганбат: Бид нар юу байна л даа. Энэ бас юмаа нэг ойлгож өгөхгүй л байгаа юм шиг харагдаад байх юм. Эд нарын ярьж байгаа юмыг ингээд харах юм бол энэ цэргийн алба хаасан, энэ цэргийн мэргэжилтнүүд гайхахаар л зүйл л яриад байна л даа. Арга ч үгүй байх л даа цэргийн алба хаасан хүн бараг алга байна шүү дээ энэ дотор чинь. Уг нь бүгдээрээ л Нараа хаасан уу? Сайн байна. Хугацаат цэргийн алба хаасан байх тийм үү? Тэгээд яг нэг Жадамбаа генерал шиг, Авхиа генерал шиг, Ёндон генерал шиг тийм манай цэргийн мэргэжилтнүүд байгаа л байх л даа. Гэхдээ Батлан хамгаалах яам бол Боловсролын яам биш шүү. Яг тэр англи хэл, компьютер, өөр юу гээд байлаа жолооны курс энэ тэр бол яг төрөл мэргэжлийн хэрэгцээтэй цэргийн анги. Тэр хүмүүстээ хэрэгтэй. Хавтгайруулж болохгүй. Тийм юм байдаггүй. Бүх нийтийн цэргийн албыг нь хаалгаад жил болгоныг 20 мянган цэрэг татахад л болох юм шиг харагдаад байгаа. Эрүүлжүүлээд яг цэргийн өнөөдөр чинь хэрэгтэй цагт, хэрэгтэй үед эх орон дуудахад бэлэн байх хэрэгтэй байна л даа бүгдээрээ.

Бид нар ингээд дэлхийн нөхцөл байдлыг харж байхад бол тэр тэрбум 800 сая Исламын шашинтай улсын хажууд тав зургаахан сая хүнтэй Израил өөрийнхөө батлан хамгаалах чадварыг хадгалж чадаад байна л даа. Энэ мэтчилэнгээс ийм юмнуудаас бид нар суралцах хэрэгтэй байна. Энэ дээрээ анхаарч ажиллах шаардлага байна шүү. Тэгээд бас энэ юм хумаа хараад үзээд, энэ цэргийн анги нэгтгэлүүд энэ батлан хамгаалах салбар энэ тал дээр бас нэлээн анхаарч ажиллах шаардлага байна аа. Тэгэхгүй бол одоо тэр төсөв хөрөнгийг нь нэгэнт улс л юм чинь энэ яам байх л ёстой шаардлагатай л юм бол тэр хэмжээнийх нь бусад улс орнуудын дундаж нь биш юм гэхэд дунджаас нь арай доогуур хэмжээнд нь тэр 2 хувь, нэг хувьд нь хүргэх хэрэгтэй. Тэгэхгүй бол ДНБ-ий 0

хэдэн хувиар төсөвлөөд санхүүжүүлээд ингэж явж болохгүй ээ.

Энэ одоо цэргийн алба хаах шаардлагатай, цэргийн эрдэмд суралцах ийм хүмүүсээ бүгдийг нь хамруулах хэрэгтэй. Бүгдээрээ 10км хэрэгцээт цагт гүйчихдэг, буу бариад буудчихдаг, ийм юмыг нь анхан шатад автомат буу бариад үзчихсэн байдаг. Ийм хэмжээний юмыг нь бэлдэж хийж өгвөл энд бас мөнгө төгрөг хайрлах ёсгүй шүү дээ. Тийм нөхцөл байдал гадна дотнын нөхцөл байдал бид нарыг шаардаж байна. Энэ дээр бид нар анхаарч ажиллах ёстой шүү гэдгийг бас энэ протоколд хэлж тэмдэглүүлье. Цааш цаашидаа бид нар анхаарах шаардлага байгаа юм байна.

Г.Тэмүүлэн: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг ирье. Би нөгөө зарчмын зөрүүтэй саналаа л хэлэх гээд байгаа шүү дээ. Энэ нөгөө түрүүн Батцэцэг сайдын бас танилцуулгыг сонслоо. Тэгээд манай Гадаад харилцааны яам бол их сайн ажиллаж байгаа. Яг нөгөө үзэл баримтлалынхаа дагуу улс төр дипломатын аргаар эдийн засаг, улс төр, соёл бүх энэ харилцаа хамтын ажиллагааг маш өндөр түвшинд авч явж байгаа. Ялангуяа одоо энэ өндөр дээд айлчлалуудыг бол сүүлийн жилүүдэд маш сайн хийж байгаа. Би өөрөө бас Гадаад яаманд ажиллаж байсан хүн. Гэхдээ у уучлаарай. Би одоо зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Ямар санал гэхээр энэ нөгөө дипломат корпус гэдэг энэ олон улсын мэдээлэл солилцоо ёслол арга хэмжээний төв барих гээд 12 тэрбумын үнэтэй ийм барилгын ажил байгаа тэгээд энийг бол би энэ удаадаа хасаж өгөөч гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм аа.

Тэгээд тайлбарлах юм бол ерөнхийдөө л бид бүгд л ердөө ярьж байгаад л энэ асуудлын хүрээнд л тайлбарлагдана. Угаасаа бид нар чинь нөгөө бүхий л төрлийн урт богино дунд

хугацааныхаа хөгжлийн хөтөлбөрүүдэд аль болох л төрийг данхар байлгахаас нь сэргийлнэ, төрийг цомхон болгоно, хувийн хэвшилээ дэмжинэ гээд ингээд явж байгаа. Гэтэл яг одоо ингээд байшин бариад яваад байх юм бол яг энэ байшинг чинь дагаад нөгөө орон тоо чинь нэмэгдэнэ, нөгөө урсгал зардал чинь нэмэгдэнэ гээд ингээд явж байгаа. Энэ аудитын дүгнэлтэд бас байгаа юм. Яах вэ энэ хууль талаасаа бас шаардлага хангасан эсэхийг нь мэдэхгүй. Орон тоо урсгал зардлын талаарх тооцоо судалгаа байхгүй гэж оруулсан байна лээ.

Тэгэхээр мэдээж энэ зураг төсөв нь байгаа л байх. Гэхдээ нөгөө бид нарын энэ ирэх шинэ 30 жилдээ баримтлах гээд байгаа энэ зарчмын эсрэг юм биш үү. Ямар нэгэн тийм гоё ганган байшин барьснаар энэ улс төр дипломатын аргаар хангагдах юм болов уу. Би бас тэрийг сайн ойлгохгүй байна. Тэгэхээр магадгүй ийм байшин барилга ёслолын арга хэмжээний том төв хэрэгтэй байгаа бол бас хувийн хэвчлүүдийнхээ энэ байшин барилгыг ашиглаад явж болдоггүй юм болов уу? Улсын төсвөөр бүхэл бүтэн 12 тэрбум төгрөгөөр ийм ёслол хүндэтгэлийн мэдээлэл солилцох арга хэмжээ хийх ийм төв байгуулахыг би огт дэмжихгүй байгаа юм аа. Дахиад л эргээд л ярих юм бол нөгөө төсвийн эрэмбэ дараалал гэдгээ бол энэ дээр бас барихгүй л байгаа юм шиг санагдаж байна. Тэгэхээр одоо Монгол Улс чинь нөгөө л бид нарын өдөр болгон шахам хүн болгон ярьдаг нөгөө ганц шахам бүтээгдэхүүн хоёрхон бүтээгдэхүүнээс хамааралтай экспортын үнээс хамааралтай ийм улс байж байдаг. Тэгээд нөгөө мөчлөгөө дагаад нэг овоо үнэ нь гайгүй байгаад овоо их нүүрс ингээд бараа бүтээгдэхүүн зарах үед ингээд яг бүх байгаа мөнгөө тавьж туугаад тэгээд нөгөө үнэ нь буураад орлого нь багасаад ирэхийн цагт яах юм болоо гэдэг асуудал яг энэний ард дахиад л явж байгаа юм.

Тийм учраас энийг хасаж өгөөч ээ гэсэн. Энэ удаа ч гэсэн дахиад л энэ мөнгө

ингээд нэгэнт байгаа юм бол одоо өвөл болж байна. Нөгөө хүүхдүүд чинь эмнэлгийн ор хүрэлцдэггүй шүү дээ. Ингээд л ерөөсөө газраар зулаад л хүүхдүүд нь хэвтэж байдаг, нөгөө утаандаа баригдаад л явж байна. Нөгөө гэр хороолол нь яах юм. Хөдөө хүртэл ингээд цэцэрлэг байшин нь хүртээмжгүй байдаг юм байна лээ. Гэр цэцэрлэг дотор 20, 30-аараа суугаад хичээллэж байна гээд. Ингээд яг шийдэх ёстой тулгамдсан асуудлууд д зөндөө байгаа маш их байгаа. Мэдээж гадаад харилцаа чухал, үндэсний аюулгүй байдал чухал. Гэхдээ Монгол Улс Монгол хүнээс илүү чухал ийм үндэсний аюулгүй байдал гэж байдаг юм болов уу гэж би бас сүүлийн үед маш их гайхаж байна аа.

Тэгэхээр энэ удаадаа бол энэ саналаасаа татгалзаад манай гишүүд ч гэсэн энэ ёслол хүндэтгэлийн арга хэмжээний төвийг улсын төсвөөр 12 тэрбум төгрөгөөр барих энэ ажлыг хойшлуулж.

Г.Тэмүүлэн: Баярмаа гишүүн бол гишүүнийхээ хувиар бас зарчмын зөрөөтэй саналын томьёолол гаргаж байна. Яг албан ёсоор бичгээр ирүүлсэн саналын томьёоллын хуудсан дээр 2 санал ирсэн байгаа. Нэг нь сая ганицхан нөгөө дипломат корпустай холбоотой олон улсын мэдээлэл солилцоо ёслол арга хэмжээний төв барих асуудлыг хасах гэдэг саналыг гаргасан. Тэрийгээ бас саналаа бас тайлбарлалаа.

Хоёр дахь санал нь бол НҮБ-ын цөлжилттэй тэмцэх суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж барихыг хасах гэсэн энэ зардлыг бас хасахаар өгсөн байгаад байгаа. Гэхдээ манай Байнгын хороонд хамаарах асуудал биш. Энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хамаарахаар асуудал байгаа учраас маргаашийн Байнгын хороонд бид нар бас энэ саналыг цааш нь шилжүүлъя. Байнгын хороонд. Сая Баярмаа гишүүний гаргаж байгаа саналтай холбогдуулаад.

Уг нь бол дэгээрээ тайлбар байхгүй. Тэгэхдээ яах вэ Батцэцэг сайд та нэмээд яах вэ бас тайлбар мэдээлэл өгчих. Тэгээд ямар ч байсан санал хураалгана гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор. Баярлалаа.

Д.Батцэцэг: Баярмаа гишүүний санаа зовж байгаа асуудалд ойлгож байна. Эмэгтэй гишүүдийн хувьд ч гэсэн аль болохоор хэмнэе хасъя гээд. Бид нар сүүлийн 8 жил энэ гадаад харилцаанд ерөөсөө хөрөнгө оруулалт ч хийгээгүй. Ер нь бол бас Монгол Улсын нүүр царай гадаадад, дотоод ч бас хэцүү л болоод байгаа юм. Байшин барилга түрээсэлж байгаа төлбөр нь жил болгон нэмэгдээд тэгээд ер нь төрийн тэргүүнээс манай Засгийн газраас бас бид нар өнгөрсөн жилүүдэд ярьж байгаа хилийн чанадад байгаа дипломат төлөөлөгчийн газруудынхаа өөрийн үндсэн байрнуудыг жилд нэг байр засаж байя. Мааш өндөр түрээстэй газруудыг түрээсийг нь багасгах болж өгвөл өөрийн хөрөнгөтэй больё гэдэг ийм зорилт тавьж байгаа. Ирсэн гаднын зочдод яг үнэндээ бид нар ийм олигтой бас нүүр тахалчих хүлээн авалтын байр сав ч ер нь байдаггүй. Тэгээд хувийн хэвшилээс мэдээж түрээсэлдэг. Хувийн хэвшилдээ бол сайн. Тэгэхдээ мааш их мөнгөөр бид нар уулзалтын заалууд хүртэл энэ ордноос өөр олигтой уулзалт танхим байдаггүй.

Тэгэхээр дипломат төлөөлөгчийн газруудын тоо цаашидаа нэмэгдэнэ. Нэмэгдэхдээ гаднын дипломат төлөөлөгчийн газрууд бас манай дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газраар дамжуулаад манай байр үндсэн үл хөдлөх хөрөнгүүдийг түрээсэлдэг, хөлсөлдөг, мөнгө төгрөг өгдөг, энэ арилжааны шугамаар явдаг. Тэгэхээр энэ хүсэлтийг бас олон жил энэ дипломат төлөөлөгчийн газрууд тавьж байгаа юм. Тэгэхээр ингэж нийлж олон улсын байгууллагууд дипломат төлөөлөгчийн газрууд Монголд үйл ажиллагаа явуулах спорт уралдаан зохион байгуулах, арга

хэмжээ хийх. Энэ нь Баярмаа гишүүн ээ юу яах юм. Арилжааны журмаар явагдана. Манай яамны дэргэд байж байгаад салаад ТӨХ-нд оччихсон дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар гээд байгууллага байдаг. Нэлээд том орон тоотой. Энэ байгууллага бол бүхий л тэнд ажиллах хүмүүс нь бэлэн байж байгаа. Тэр энэ байшингийн барих зураг төсөв нь ч гэсэн тэр байшинтайгаа залгаад баригдах юм.

Тэгэхээр орон тооны хувьд тэр дипломат байгууллага чинь үйлчилгээ эрхлэх газар нь өөрсдөө эрхэлнэ. Энэ төсөвт ямар нэгэн дарамтгүй арилжааны журмаар төлбөр аваад үйлчилгээгээ яваандаа үзүүлнэ ээ. Гаднын Олон улсын байгууллага дипломат төлөөлөгчийн газрууд, Гадаад харилцааны яаманд дэмжлэг үзүүлээд өгөх ийм барилга байгаа юм шүү. Бид нар өнгөрсөн жилүүдэд мааш олон удаа бүх юмаа хасаж байсан. Одоо тэгээд дандаа бас дандаа ядуу зүдүү байна дандаа тэгийг гээд тэгэхгүй бүх салбар болгон өөртөө хэрэгтэй гэсэн зүйлүүдээ нэлээд нарийн тооцож байгаад гаргаж ирсэн ийм санал байгаа юм гэдгийг эрхэм гишүүддээ хэлмээр байна аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Байнгын хороонд харьяалагддаг яамдуудынхаа төсвийг хэлэлцлээ. Бас өнгөрсөн жилтэй харьцуулбал тодорхой хэмжээгээр бас төсөв нэмэгдүүлж орж ирсэн байна. Түүнд бас гишүүний хувьд бас талархалтай байна. БХЯ-ны хувьд бас нэмэгдэж байгаа төсвийг цаашидаа хугацаат цэргийн албан хаагчдын амьдрах байр орон сууц, нөхцөл, тэгээд сургалтын хөтөлбөр рүү илүү чиглүүлж өгөх нь зүйтэй харагдаж байгаа.

Дээрээс нь хугацаат цэргийн албан хаагчидтай холбоотой энэ хууль тогтоомжууддаа нэлээд өөрчлөлт хийхгүй бол бас өнөөдрийн байдлаар бол

үнэхээр цэрэгт явах хүүхэд олдохоо байсан. Энэ бол нэг юм хэлээд байгаа учраас энэ дээр дүн шинжилгээ хийж цаашидаа хууль эрх зүй, үйл ажиллагаанд, сургалтын төсөл хөтөлбөр дээрээ эргэж өөрчлөлт хийхгүй бол болохгүй байна гэдгийг харуулаад байгаа юм аа. Энэ дээрээ анхаарч ажиллах ёстой. Гадаад яамны хувьд айлчлалуудыг олон зохион байгуулсан. Одоо хэрэгжилт чухал. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 14 мега төсөл тавигдчихсан. Энэ 14-ийг мега төслийг 2025 оноос эхлээд хэрэгжүүлнэ гээд зориод явж байна. Төсөв дээр 14 мега төслийг хэрэгжүүлнэ гээд бүтэн төсөв тавьсан нэг ч ажил алга. Тэгээд юу тавьж байна вэ гэхээр зэрэг ард нь гадна, дотнын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэсэн ийм л зүйлүүд тавьсан байгаа. Тэгээд яг өнөөдөр харахад амжилттай хэрэгжинэ гэхэд бол хэцүү харагдаж байгаа юм.

Энэ дээр гол нөлөө үзүүлэх газар бол Гадаад яам, гадаадад байгаа дипломат төлөөлөгчийн газар Элчин сайдуудын хийх ажил их байгаа гэдэг нь харагдаж байгаа. Зөвхөн айлчлалуудыг зохион байгуулах гэрээ хэлцэл байгуулсан төдийгөөр тэдгээрийн ажлыг дүгнэх биш Монгол Улсаас бараа бүтээгдэхүүнүүдийг тухайн байгаа орондоо хэр хэмжээгээр экспортлоход дэмжлэг үзүүлж гарц гаргалгаа нээж байна уу? Эргээд Монгол Улсад гаднын хөрөнгө хураалтыг хэр хэмжээгээр татаж авчирч байна вэ гэдгээр л тэр хүмүүсийн ажлыг дүгнэх ёстой гэж үзэж байгаа.

Тийм учраас 2025 онд энэ томоохон төслүүдийг хэрэгжүүлэх дээр онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна гэж ингэж харагдаж байна.

Дараагийн асуудал бол Онцгой байдлын газартай холбоотой Шадар сайдын эрхлэх асуудалтай холбоотой өвөлжилтийн бэлтгэл, хаваржилтын бэлтгэл асуудлууд бол нэн чухал асуудал аа. Өнгөрсөн өвөл зуд боллоо 10 гаруй сая

толгой малаа алдлаа. Олон хүний амь нас эрсэдлээ гээд зөндөө олон асуудлууд гарсан. Бид нарт хангалттай сануулга байгаль дэлхий өгч байна. Энэ зуны байдлаас харахад ч гэсэн хур бороо элбэгтэй түүнийгээ дагаад өвөл хур тунадас орох, цас орох, зуд болох ийм байдал ер нь ажиглагдаж байна шүү дээ. Урт өвөл ч болох юм байна нэг илүү сартай өвөл болох юм байна.

Тийм учраас өвс тэжээлээ эртнээс бэлтгэх аймаг сумандаа үүрэг даалгавар өгөх, энэ аймаг, сум дундын отрын бүс нутгийг тодорхой болгох хил залгаа газрууд дээрээ отор нүүдэлд гарах газар, бэлчээр нутгийг бэлтгэх, усжуулалтын арга хэмжээ авах гэх мэтчилэн маш олон од өвс шатахууныхаа нөөц тэжээлийг бэлтгэх, техник хэрэгсэл мөн өвөлжилтийн аймгуудад эрсдэлийн үнэлгээ хийх албан хаагчдынхаа бэлэн байдал техник хэрэгслийг хангах гэх мэтчилэн энэ өвөлжилтийн бэлтгэлд зориулж маш олон ажлууд хийх шаардлагатай. Нэмэгдэж хуваарилагдаж байгаа төсвүүдийг энэ чиглэл рүү онцгой анхаарал хандуулах. Нөгөө талаасаа малчид, иргэдийн хувийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах.

Аймгийн төв, сумын төвүүдийн дулааны станц энэ дэд бүтцийн асуудал түлээ нүүрсний асуудал дээр онцгой анхаарч ажиллах ийм шаардлагатай.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн зарчмын зөрөөтэй саналаа танилцуулъя.

Ч.Анар: Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр 2 санал оруулсан байгаа. Нэг нь зохицуулалт хийх санал.

Түрүүн яригдсан БХЯ-ны кибер аюулгүй байдлын программ хангамжийн техникийн төлбөр ач холбогдлын хувьд хойшоо тавигдчихаад байгаа 3.2 тэрбум. Энийг зохицуулалт хийж шийдэж өгнө үү гэж оруулж байгаа юм. Тэгэхээр энэ ямар

асуудал болоод байгаа юм бэ гэхээрээ БХЯ нь өөрөө гаднын халдлага довтлогоос хамгаалах үндсэн чиг үүрэгтэй. Тэгэхээр өнөөдөр дэлхий дээр технологийн дайн эрин үе чинь өөр болсон. Кибер аюулгүй байдал гэдэг өөрөө Монгол Улсын тусгаар тогтнолын нэг хэсэг. Технологийн хэмжээнд сонгуульд нөлөөлөх цаашилаад хувь хүний иргэний мэдээлэл үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, байгууллагуудын дэд бүтцийн мэдээлэл авах хэмжээнд батлан хамгаалах салбар ажиллах ёстой.

Тэгэхээр энэ бодит жишээнүүд бол бусад улсын сонгуульд нөлөөлдөг үйл ажиллагаагаараа илрээд сонсголуд яваад эхэлсэн байгаа. Тэгэхээр Монгол Улсын энэ дархан халдашгүй байдалд кибер аюулгүй байдлаараа зорилтот бүлгүүд энэ дээр бол тодорхой нэр зааж болохгүй. Сүүлийн 2 жил систем дээр халдлагууд үйлдээд эхэлчихсэн байгаа. Өөрөөр хэлбэл үндэстний аюулгүй байдал батлан хамгаалах салбарт бол манайх аль хэдийн гаднын довтолгоонд өртөөд эхэлчихсэн байгаа.

Тэгэхээр энэ асуудлаа ач холбогдлыг нь чухалчилж өгөөч ээ. Тэгэхээр энэ асуудлыг чухалчлахгүй бол маш үнэтэй тоног төхөөрөмж тавьчихсан. 1.5 сая хэрэглэгчид дахиад энэ дээгүүр нөгөө сонгуулийн маань систем явдаг, төрийн байгууллагуудын мэдээллийн нууц маань явдаг. Энэ маань ингээд зүгээр лицензийн төлбөр төлөгдөөгүй гээд огт ажиллаагүй байгаад байгаа юм. Энэ асуудлыг ишидээж өгөхийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдээсээ хүсээж байна.

Хоёрдугаар асуудал энэ бол яах вэ 2025 оны хөгжлийн төлөвлөгөөндөө орчихсон байгаа заалтууд. Энийг хуульдаа нийцүүлээд Төсвийн тухай хууль дээрээ нийцүүлж уялдуулах асуудал оруулж ирж байгаа юм. Тэгэхээр энэ бол заавал ч үгүй уялдаж байж энэ Төсвийн тухай хууль маань батлагдах ёстой. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хоёр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг танилцуулаад санал хураалтыг явуулъя.

Нэгдүгээрт. Баярмаа гишүүний гаргасан санал байгаа.

2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын 9.1.2-т дипломат корпус олон улсын мэдээлэл солилцоо ёслол арга хэмжээний төв Улаанбаатар барихыг -12 тэрбум төгрөгийн зардлыг хасах гэсэн саналын томъёолол гаргасан байна.

Баярмаа гишүүний саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

Энэ санал хураалтын дүн юу болов? Техникийн алба ажлын алба асуугаарай. Санал хураалтын дүн техникийн алдаа гарсан бололтой.

Саяын уншсан томъёоллоор санал хураалтыг дахиж явуулъя.

Санал хураалт.

Энэ дуугарахгүй байна. Туршилтын санал хураалт дахиад нэг явуулаадахъя. Техник ажиллахгүй байна энэ туршилтынх.

Ажиллаж эхэлж байх шиг байна.

Дахиад нэг туршилтынхыг явуулаадахъя. Болж байна. Албан ёсоор санал хураалтыг явуулъя.

Баярмаа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг түрүүн уншиж танилцуулсан, дипломат корпустай холбоотой энэ зардлыг хасах гэсэн томъёолол байгаа. Баярмаа

гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Татгалзсан 19. Ингээд Баярмаа гишүүний гаргасан саналын томьёолол дэмжигдсэнгүй ээ.

Анар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаад байгаа. Анар гишүүний гаргасан саналын томьёолол бол 19.1.1.2 гамшигаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт гэснийг өөрчлөх санал нь гамшигаас хамгаалах техник, тоног төхөөрөмж гэж бараг редакцын маягтай засварын өөрчлөлт байна шүү дээ тиймээ. Хуульд нийцүүлж байгаа асуудал юм байна шүү дээ тиймээ.

19.1.1.2 гээд 19.1.1.2 дотроо хэмжих нэгж нь хувь гэснийг хэмжих нэгж нь тоо гэж өөрчлөх. Тэгэхээр илэрхийлэгдсэн байгаа нэгж нь хувиар илэрхийлэгдсэн 57 хувь гэж байсан уу? Тэгэхээр энэ тоогоор шилжихээр бас асуудалгүй юу? Тодорхойгүй байдал үүсгээд байна аа. Илэрхийлэгдсэн тоо нь манай онцгойнхон бас давхар анзаарч байгаа байх 19.1.1.3 хэмжих нэгж нь хувь гэснийг хэмжих нэгжийг нь тоо гэж өөрчлөх гэсэн ийм саналыг гаргаж байгаа юм.

Анар гишүүн энийг тодруулчихъя.

Ч.Анар: Энэ гамшигаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт гэхээр тодорхойгүй байгаа байхгүй юу. Үр дүнг нь хэмжих бололцоогүй. Одоо түрүүний аудитын газрын энэ зовлон дахиад энэ нөгөө бас энэ Монгол Улсын Засгийн газрын төсвийн зарцуулалтын үр дүнг хэмжихэд ийм тодорхойгүй байдлууд нь яаж үр дүнгээ хэмжиж байгаа юм бэ гэдгийг нь тодорхойгүй байгаа болохоор илүү тодорхой болгож өгч байгаа юм аа. Хэмжих нэгжийг хувь гэдгийн тоо болгох нь илүү тодорхой болгох асуудал байгаа, нэгт,

Хоёрдугаарт энэ нь өөрөө 2025 оны хөгжлийн төлөвлөгөөндөө тусгагдчихсан. Тэгэхээр Төсвийн хууль дээрээ эндээ уялдуулан заагдах ёстой. Хэрвээ энэ нь заагдахгүй үр дүнгээ хэмжих дээрээ тодорхойгүй яаж хэмжих нь аягүй тодорхойгүй орж ирээд төсвийн гүйцэтгэлийг хэмжих бололцоогүй болж байгаа юм. Ер нь хуулийн уялдааг л зохицуулж байгаа асуудал байгаа юм.

Г.Тэмүүлэн: Санал хураалтыг явуулъя.

Анар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт. Гишүүд анхаараарай. Дэмжье гэдгээр.

Алтанишагай гишүүн горимын санал гаргая. Алтанишагай гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанишагай: Энэ төхөөрөмж ажилласангүй.

Г.Тэмүүлэн: Алтанишагай гишүүний саналаар санал хураалтыг дахин явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай санал хураалтыг дахин явуулъя. Алтанишагай гишүүний саналаар горимын санал 60 хувиар дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн учраас Анар гишүүний гаргасан саналыг дахин хураалт явуулъя. Томьёоллыг уншсан байгаа. Анар гишүүний зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

55 хувиар дэмжигдлээ.

Батсүмбэрэл гишүүн дэмжсэнээр орсон юм байна. 60 хувь болж байгаа юм байна.

2 дахь санал нь шинээр дэд бүлэг нэмэх 23.2.2 22 дээр төсөлд тусгагдаагүй гадаад харилцааны сайд буюу 23.2.2 дээр Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг

гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулах шалгуур үзүүлэлт Гадаад улстай хийх хэлэлцээр, хэмжих нэгжийн тоо, суурь нь 2023, суурь түвшин нь 64, 2025 оны зорилтот түвшин нь 75 гэсэн ийм байна.

Анар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт

50 хувиар дэмжигдсэнгүй.

Ганбат гишүүний кноп ажилласангүй. Ганбат гишүүн та горимын санал гаргах уу? Ганбат гишүүн.

Д.Ганбат: Би дэмжсэн санал өгсөн юм тэгсэн нөгөө талд нь гарчихсан байна.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний саналаар горимын санал хураалт явуулна. Тэгээд санал хураалтыг дахин явуулъя.

Санал хураалт

55 хувиар дэмжигдлээ.

Ганбат гишүүний горимын санал дэмжигдсэн учраас саяын Анар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дахиж явуулъя дэмжье гэсэн томъёоллоор.

Санал хураалт.

60 хувиар дэмжигдсэн байна.

Дараагийнх нь Анар гишүүний гаргасан санал шинээр нэмэх бүлэг 23.5 төсөлд тусгагдаагүй 23.5 дээр үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх гээд Гадаад харилцааны сайд дээр байгаа. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх. Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь, он түвшин, зорилтот түвшин байхгүй юм байна.

Энэ томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт. Дэмжье гэдгээр санал хураалт явуулна.

45-аар саяын санал дэмжигдсэнгүй. Анар гишүүн.

Ч.Анар: Би дахиад тайлбар тавьяаа. Энэ орж байгаа өөрчлөлтүүд маань хөгжлийн төлөвлөгөөндөө 2025 оны хөгжлийн төлөвлөгөөндөө бид нар баталчихсан. Бүгдээрээ баталчихсан оролцоод. Тэгэхээр энэ маань өөрөө төсвийн тухай хуультайгаа нийцүүлж уялдуулан нийцүүлж байгаа л өөрчлөлт шүү дээ. Бид нар тэгэхээр баталсан юмаа дэмжихгүй байна гээд тэгэхээр энэ өөрөө дахиад Их Хурал дээр орж ирээд л угаасаа уялдуулж нийцүүлж оруулахгүй бол төсөв маань өөрөө энэ зөрчилтэй болох асуудал л байгаа юм. Тэгэхээр энийг маань та бүхэн сайн ойлгоорой энэ тэгэхээр шинэ саналууд биш 2025 оны хөгжлийн төлөвлөгөөндөө энэ зүйл заалтууд бүгдээрээ тусгагдаад бид нар өөрснөө баталчихсан байгаа заалтууд шүү.

Г.Тэмүүлэн: Сая тэгээд санал дэмжигдсэнгүй дээ.

Батсүмбэрэл гишүүн горимын санал гаргаж байгаа юм байна.

Н.Батсүмбэрэл: Сая миний техник ажилласангүй. Тэгэхээр дахин санал хураалт явуулж өгнө үү?

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүний техник ажиллагаагүй. Санал хураалтыг дахин явуулах горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Горимын санал 60 хувиар дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн учраас саяын Анар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дахин санал хурааа дэмжье гэдэг санал хураана.

Санал хураалт.

Анар гишүүний гаргасан санал 60 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх нь шинэ бас дэд бүлэг нэмэх 23.5.1 хөтөлбөрийн зорилт хүргэх дүн нь дэлхийн Монголчууд 2 цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, арга хэмжээний хэрэгжилт, хэмжих нэгж хувь суурь он 2023 суурь түвшин 95, 2025 оны зорилтот түвшин 100 гэсэн ийм санал гаргасан байна. Хөтөлбөр дээр.

Анар гишүүний гаргасан саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

55 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх нь шинэ дэд бүлэг нэмэх 23.5.2 төсөлд тусгагдаагүй Монгол үндэстний үнэлэмж цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, шалгуур үзүүлэлт, арга хэмжээний хэрэгжилт, хэмжих нэгж хувь, суурь он 2023, суурь түвшин 95, 2025 оны зорилтот түвшинд 100 гэсэн ийм дэд бүлэг нэмэхээр санал оруулж байгаа юм байна. 23.5.2 дээр. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна.

Санал хураалт.

Энэ санал 50 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийнх Батлан хамгаалахын сайд дээр 27.1.1.1 дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь өссөн дүнгээр энэ хэсгийг хасаж түүний оронд зэвсэгт хүчний нисэгчгүй нисэх хэрэгсэл, дрон, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт

техник хэрэгслээр хангах шалгуур үзүүлэлт, техник хэрэгслийн хангалт, хэмжих нэгж хувь, суурин 2023 суурь түвшин 8.5 зорилтот түвшин 20 гэсэн ийм өөрчлөлтийг гаргаж байгаа юм байна.

Санал хураалт.

Анар гишүүний гаргасан.

Энхбаяр гишүүн асуулт асууя.

Ж.Энхбаяр: Энэ 8.5 суурь гэдгээ яаж гаргаад байна аа? Энэ зэвсэг техник хангалтын асуудал тэгээд яаж 20 хувь гэдгийг яаж тооцож гаргаад байна? Энэ хооронд 20 хувь хүрэхийн тулд наадах чинь шууд хөрөнгө оруулалтын асуудал хөндөгдөнө гэсэн үг шүү дээ.

Байгаа суурь зэвсэг техникийн хангалтыг 20 хувь гээд сая энэ тусгай зориулалтын тоног төхөөрөмж нэмэгдэнэ гэдэг чинь хэдэн харваас хэдэн 100 тэрбум төгрөгийн асуудал болж байна шүү дээ. Тэгэхээр та энийгээ хаанаас ямар тоо аваад яаж ийм санал хураалт гаргаж өгөөд жанжин штаб гаргаж өгөөд байгаа юм уу, Батлан хамгаалах яам гаргаж өгөөд байгаа юм уу? Тэр тооцоо байхгүй ердөө болохгүй. Наадах чинь аягүй тийм осолтой томьёоллууд орж ирээд байна л даа.

Анар гишүүн саналаа тайлбарлая.

Ч.Анар: Энэ 2025 оны хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөндөө бид нар тусгаад аль хэдийн баталчихсан байгаа асуудал. Тэгээд энийгээ төсөв рүүгээ уялдуулж суулгаж өгөөгүй болохоор энэ чинь өөрөө дахиад нөгөө Төсвийн тухай хуулиа уялдуулж батлах ёстой тэр тэр зарчмыг л хийж байгаа гэсэн үг. Энэ өөрөө харьяалахад яам Төсвийн байнгын хорооноосоо ороод ирчихсэн байхгүй юу. Төсөв нь байгаа. БХЯ-ны ерөнхий захиран зарцуулагчийн эрх мэдлийн хүрээнд нь байгаа байхгүй юу. Төсөв нь байгаа. Тэгээд энэ 2025 оны бид нарын өөрсдөө

баталчихсан байгаа юундаа процессын хувьд яасан бэ гэхээр энэ төсвийн уялдааг зохицуулах саналууд маань 6 сард орж ирээд төсөвтэйгөө уялдах найруулгыг 10 сарын 18-нд хийх ёстой. Гэтэл нөгөө сонгуулийн үеэр хийгдээгүй учраас яг тулгаж орж ирж байгаа.

Тэгэхээр энэ өөр Байнгын хороо ч юм уу Их Хурлын чуулган дээр угаасаа л ороод л ирэх л асуудал байгаа юм л даа. 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд энэ заалтууд бүгдээрээ орчихсон байгаа л асуудал.

Г.Тэмүүлэн: Санал хураалт. Дэмжье гэдгээр санал хураа.

55 хувиар дэмжигдлээ. Анар гишүүн өөрөө дэмжсэнээр орж байгаа юм байна 60 хувь.

Шинээр нэмэх 27.1.1.2 Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл цэргийн техникийг шинэчлэх, шалгуур үзүүлэлт, бэлэн байдлын түвшин, хэмжих нэгж нь хувь, суурь он нь 2023, суурь түвшин 18, зорилтот түвшин 28 гэсэн байна.

Санал хураалт.

55 хувиар дэмжигдсэн байна.

2 санал байгаа юм байна Анар гишүүнийх.

27.1.1.3 шинээр нэмэх, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх шалгуур үзүүлэлт хэрэгжилтийн хувь хэмжих нэгж хувь, суурь он 2023, суурь түвшин 25, зорилтот түвшин 30 гэсэн байна.

Г.Тэмүүлэн: Дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Сүүлийн санал байна.

27.1.1.4 шинээр нэмэх, үндэсний сөрөн засварлах чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, шалгуур үзүүлэлт нь арга хэмжээний хэрэгжилт, хэмжих нэгж нь хувь, суурь он нь 2023, суурь түвшин нь 10, зорилтот түвшин нь 15 гэсэн байна.

Анар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт.

65 хувиар дэмжигдлээ.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд танилцуулах учиртай байгаа. Манайд чинь Төсвийн байнгын хорооны гишүүд байгаа билүү? Батсүмбэрэл гишүүн байхгүй байна. Би танилцуулчихъя тэгвэл, миний бие танилцуулъя.

Ингээд Төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ. Гишүүдэд баярлалаа.

14.25 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС УРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

